

Барилга, хот байгуулалтын сайдын  
2019 оны 02 дугаар сарын 34-ны өдрийн  
тоот тушаалын хоёрдугаар хавсралт

**ТАРИАЛАНГИЙН ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН  
УЛСЫН ХЯНАН БАТАЛГААНЫ АЖЛЫН АРГАЧИЛСАН ЗААВАР**

Гарчиг	4
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	4
Ажлын үе шат ба ажилбарууд	5
1.БЭЛТГЭЛ АЖИЛ	7
1.1.Мэдээлэл цуглуулах	7
1.2.Нэгж талбар	9
1.3.Агаар, сансрын зураг ашиглах	10
1.4.Ажлын зураг	10
1.5. Мониторингийн цэг	11
1.6.Хөрсний хээрийн судалгаа	13
1.7.Бэлтгэл ажлын тайлангийн агуулга	14
ХОЁР.ХЭЭРИЙН СУДАЛГАА	16
2.1.Ярилцлагын судалгаа	16
2.2. Хянан баталгааны үзүүлэлтийг тодорхойлох	17
2.2.1.ТАРИАЛАНГИЙН ТАЛБАЙН СУДАЛГАА	18
1.ХӨРСНИЙ УРЖИЛ ШИМТ ҮЕ ДАВХАРГЫН ЗУЗААН	18
2.ХӨРСНИЙ ЯЛЗМАГИЙН АГУУЛАМЖ	19
3.ХӨРСНИЙ УРВАЛЫН ОРЧИН	19
4.НИТРИТ АЗОТ	20
5.ХӨДӨЛГӨӨНТ ФОСФОР	20
6. ХӨДӨЛГӨӨНТ КАЛИ	20
7.ГАДАРГЫН ТӨРХ БАЙДАЛ	20
2.2.2.АТАРШСАН ТАЛБАЙН СУДАЛГАА	25
2.2.3.ТӨМС ХҮНСНИЙ НОГООНЫ ТАЛБАЙН СУДАЛГАА	26
2.3.Хээрийн ажлын тайлангийн агуулга	26
2.4.Хээрийн ажлын захиалагчийн хяналт	27
ГУРАВ. МАТЕРИАЛ БОЛОВСРУУЛАЛТЫН АЖИЛ	28
3.1.Үндсэн үзүүлэлт	28
3.2.Нөлөөллийн үзүүлэлт	28
3.3. Хянан баталгааны ажлын үндсэн мэдээллийг боловсруулах	29

3.4.Өмнө хийсэн хянан баталгааны үр дүнтэй харьцуулах.....	34
3.5.Мониторингийн цэгийн хувийн хэрэг бүрдүүлэх: .....	34
3.6.Хянан баталгааны дүгнэлт бичих: .....	34
3.7.Хянан баталгааны акт бичих .....	35
3.8. Нэгж талбарын сүлжээний зураг боловсруулах.....	35
3.8.1.Зураглах.....	36
3.8.2.Хүснэгтэн мэдээлэл оруулах .....	36
3.8.3.Зургийн эх бэлтгэх.....	36
3.8.4.Зураг хэвлэх .....	38
3.9.Хянан баталгааны ажлын тайлан.....	39
Тайлан бичих.....	39
Тоон файлыг хуулбарлах .....	41
3.10.Ажлын үр дүнг шалгах, хүлээн авах.....	42

Хавсралтууд:

Хавсралт 1. Ургамлын бичиглэлийн маягт

Хавсралт 2. Монгол орны хөрсний нэршил ба код

Хавсралт 3. Хөрсний код бичих зааварчилгаа

Хавсралт 4. Хөрсний бичиглэлийн маягт

Хавсралт 5. Хөрсний маршрутын судалгааны бичиглэл

Хавсралт 6. Мониторингийн цэгийн хувийн хэрэг

Хавсралт 7. Тариалангийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны дүгнэлт

Хавсралт 8. Атаршсан газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны дүгнэлт

Хавсралт 9. Өмнөх хянан баталгааны үр дүнтэй харьцуулах

Хавсралт 10. Ажлын даалгаварын загвар

Хавсралт 11. Ажлын даалгавар бичих заавар

Хавсралт 12. Баталгааны хуудасны загвар

Хавсралт 13. Шаардлагатай стандартын жагсаалт:

1. Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код  
MNS5641-0-2006 2x,  
MNS5641-1-2006 6x,  
MNS5641-2-2006 34x,  
MNS5641-3-2006 47x
2. Бэлчээрийн газрын хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхлагдлыг тогтоох ерөнхий шаардлага. MNS 5546:2005
3. Хөрс.Хөрсний агро-хүмийн үзүүлэлтийг тодорхойлох. MNS 3310:1991.

4. Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд. MNS3298-1990
5. Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам. MNS 2305:1994.
6. Хөрсний нийт азот тодорхойлох арга. MNS3242-1989
7. Хөрс.Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга. MNS4006-1987
8. Хөрсний чанар. pH тодорхойлох. MNSISO10390-2001
9. Байгаль орчны бохирдол, бохирдлын хяналт ба хамгаалалт. Агаар, хөрсөн дэх пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 6147:2010
10. Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS5850:2008
11. Хөрсний чанар. Органик хлорт пестицид ба полихлорт бифенилийн агууламжийг электрон баригч детектор бүхий хийн хроматографиар тодорхойлох арга. MNS ISO 10382-2012
12. Soil quality -Determination of content of hydrocarbon in the range c10-C40 by gas chromatography аргаар тодорхойлох. ISO 16703:2004
13. Ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр төрөл. MNS3985-87
14. Байр зүйн болон дэвсгэр зургийн загвар сан, таних тэмдэг. Масштаб 1:500, 1:1000, 1:2000, 1:5000. MNS 6703:2017
15. Байр зүйн зургийн загвар сан, таних тэмдэг. Масштаб 1:25000, 1:50000, 1:100000. MNS 6703:2017
16. Мета өгөгдлийн стандарт. MNS 5774

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Газрын тухай хуулийн 58-р дугаар зүйлд заасны дагуу газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа нь газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах үйл ажиллагаанд төрийн хяналтыг тасралтгүй хэрэгжүүлэх зорилгоор газрын төлөв байдал, чанарын тогтвортой, гол үзүүлэлтүүдийг хууль тогтоомжид заасан хугацаанд давтан тодорхойлж улсын хяналтад авсан анхны үзүүлэлтүүдтэй харьцуулан дүгнэлт гаргахад оршино.
2. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг эрх бүхий мэргэжлийн байгууллага хийж, дүгнэлт гаргах бөгөөд газрын нэгдмэл сангийн бүх ангилалын газрыг 5 жилд нэг удаа газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаанд заавал хамруулж байхаар заасан байдаг.
3. Хөдөө аж ахуйн газрын дотор тариалангийн талбай шиг эрчимтэй ашиглагддаг газар нутаг байхгүй. Энэ утгаараа тариалангийн хянан баталгааны ажил онцгой ач холбогдолтой бөгөөд газрын чанар төлөв байдалд өөрчлөлт гарах магадлал өндөр юм.
4. Тариалан, атаршсан газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын гол зорилго нь тариалан, атаршсан газрын хөрсний төлөв байдал, шинж чанарыг тодорхой үзүүлэлтүүдээр гаргаж, газрын төлөв байдал, чанарт гарсан өөрчлөлтийг тодорхойлж, зураглан, дүгнэлт гаргах явдал юм.
5. Тариалан, атаршсан газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг гүйцэтгэх, гүйцэтгэлд хяналт тавих, газрын төлөв байдал, чанарт гарсан өөрчлөлтийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, тайлан бичиж дүгнэлт, зөвлөмж боловсруулах, хянан баталгааны мэдээллийн сан байгуулах ажлыг нэгдсэн аргачлалаар хангахад энэ зааврын зорилго оршино.
6. Энэ зааврыг зөвхөн үр тарианы төдийгүй төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ мөн түүнчлэн тэдгээртэй адилтгаж болохоор сургалт, сорилт туршилтын ба мод үржүүлгийн зэрэг газарт ашиглана. Ажлын хэмжээг тооцох, хяналт, шалгалт тавихад үр тарианы талбай том боловч харьцангуй жигд, харин хүнсний ногоо, жимс жимсгэний болон усалгаатай талбай алаг цоог ихтэй, ажиглалт хэмжилтийн давтамж олон байх шаардлагатай.
7. Тариалангийн газрын ашиглалт нь газрын шимийг шууд ашиглаж байгаагаараа үйлдвэрлэлийн чухал ач холбогдолтой. Үүний зэрэгцээ газрын төлөв байдал, чанарт богино хугацаанд олон талын үйлчлэлээр ил далд, их бага өөрчлөлт гарах ба ялангуяа хүнсний хангамж, эрүүл ахуй, байгаль орчинд нөлөөтэй гэдгийг ямагт анхаарах хэрэгтэй.
8. Тариалангийн талбайн хянан баталгааны ажил түүний үнэлэлт, дүгнэлт бусад талбайнхаас их хариуцлагатай байх ёстой. Атаршсан талбайн хөрс жилийн ихэнх хугацаанд нүцгэн байдгаас салхины нөлөөгөөр элэгдэж, эвдрэх нөхцлийг байнга бүрдүүлдэг.
9. Ялангуяа жимс жимсгэнэ, усалгаатай хүнсний ногооны газрын гадаргыг тэгшилсэн, суваг шуудуу татсан мөн химийн бордоо гербицид хэрэглэсэн зэрэг үйл ажиллагаа хөрсний байгалийн үе давхаргыг эвдсэн, хордолт, бохирдолтыг жижигхэн хэсэгт голомтлон үүсгэсэн байх болзошгүй юм.

10. Эндээс үүдэж хянан баталгааны ажиглалт, хэмжилтийн тоон утга, давталтуудаар их ялгаатай гарах тохиолдол гарахаас болгоомжлох хэрэгтэй. Эдгээр талбайн ажиглалт, хэмжилт хийх цэгийг зөв сонгоход анхаарахын зэрэгцээ давталтын тоог олшруулан тоон үзүүлэлтүүдийн хоорондох савалгааг багасгаж, жигдүүлэх хэрэгтэй.

11. Тариалангийн газрын төлөв байдал, байдал, чанарын хянан баталгааны ажлыг З үе шаттай гүйцэтгэх бөгөөд бэлтгэл, хээрийн судалгаа, материал боловсруулалтын үе шатуудаас бүрдэнэ. Ажлын үе шат, хийх ажилбаруудыг дараах хүснэгтээр тойм байдлаар үзүүлэв.

### Ажлын үе шат ба ажилбарууд

Хүснэгт 1

Бэлтгэл ажлын үе шат	
1. Мэдээллийг цуглуулах, боловсруулах	
1	Судалгаанд хамрагдаж буй аймаг, сумдын тариалан ба атаржсан газрын байршил, кадастрын мэдээллийг талбай бүрээр тулган шалгах
2	Байгаль-нутаг дэвсгэрийн нэхцэл, газар тариалангийн үйлдвэрлэл хөгжүүлэх хүчин зүйлсийн талаарх судалгааны мэдээ, мэдээллийг цуглуулах;
3	Газар тариалангийн үйлдвэрлэлийн нийгэм-эдийн засгийн суурь нэхцэл, үр ашгийн судалгаа, энэ талаар төрөөс болон орон нутагт хэрэгжүүлж буй бодлого чиглэл, цаашдын зорилтын талаар судалж тодруулах;
4	Урьд хийгдсэн хөрсний судалгааны материал, зураглалыг судлан сөөгжилт, чулуужилт, намагжилт, довон, талхлагдал, элсний нүүлт, автогений болон техногений нөлөө болон бусад шаардлагатай мэдээллийн түүврийг гаргах;
5	Тариалангийн газар, хөрсний үржил шим, эвдэл, химижүүлэлтийн чиглэлээр хэрэгжсэн гадаад, дотоодын эрдэм шинжилгээний байгууллага, төслүүдийн хийсэн судалгааны ажлын мэдээллүүдийг цуглуулж байршилаар нь эх зурагт оруулах;
2. Хээрийн судалгааны эх зураг зохиох	
1	1:25000 масштабтай байр зүйн зураг скайнердан, газарзүйн холболт хийж, тоон хэлбэрт оруулж нэгж талбарын тоог нарийвчлан тогтоох
2	Өмнөх хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зургийг зохих проекциор холболт хийсэн байр зүйн зурагтай давхцуулан төрх байдал ба нөлөөллийн үзүүлэлтээр давхарга үүсгэх, хүрээ шугмын засвар хийх
3	Тариалангийн талбайн хөрсний нэршил, тархалтын хүрээг өмнө хийгдсэн атар газар илрүүлсэн болон хөрсний элэгдэл эвдрэл, агрехимиин картограммын судалгааны материалтай тулгаж холбогдох засварыг оруулах
4	Хиймэл дагуулын зургийн боловсруулалт хийж спектор өнгөний ялгарлаас хөрсний гадарга дээрх өөрчлөлтийн /элс хуримтлагдсан газар, усны элэгдэл эвдрэлд орсон, зам харгуй гарсан, талбайн хэмжээ, хэлбэр дүрс г.м/ байршилыг тодруулж зурагт тусгах
5	Тариалангийн талбайн гадаргын морфометрийн үзүүлэлтийг тодорхойлж, хэлбэр дүрсийг тодруулах
6	Хог ургамал, хортон мэрэгчдийн тархалт, химийн бодисын хэрэглээ, тэдгээрийн бохирдлын мэдээллийг холбогдох газруудаас авч байршилаар нь судалгааны зурагт оруулах
7	Өмнө нь тогтоосон мониторингийн цэгийн байршилыг атрибуутын хамт зурагт оруулах

8	Газрын нэгдмэл сангийн тоон мэдээллээс тариалангийн талбай орчмын газар ашиглалтын (Гадаргын болон гүний ус ашиглалт, ой, хадлан, барилга байгууламж болон бусад) төрлүүдийг байршилаар нь оруулах
3. Удирдлага-зохион байгуулалт	
1	Хээрийн судалгааны эх зургийг үндэслэн тодруулалтын судалгааны удирдамж боловсруулан зөвлөгөө, заавар, аргачалаар хангах;
2	Судалгааны ажлыг төсөвлөх, шаардлагатай багаж хэрэгсэл, эд материалыг бэлтгэх
3	Мэдээллийг нэгтгэн хөрсний хээрийн судалгааны эх зургийг 1:100000 масштабаар бэлтгэн судалгааны маршрутыг координатжуулах
4. Хээрийн судалгаа	
1	Судалгаанд хамрагдаж буй аймаг сумын удирдлага, мэргэжилтэнтэй уулзаж ажлаа танилцуулах, шаардлагатай мэдээллийн талаар аман судалгаа авах, кадастрын мэдээллээс талбай бүрийн эзэмшигч, ашиглагчийн бишртгэлийг нарийвчлан тогтоох
2	Судалгааны объектод ирж, атаршсан буюу өнжиж буй хугацаа, ургамлан нөмрөгийн нөхөн сэргэлтийн байдлыг тодорхойлох
3	Талбайн төлөөлөл болох атар газарт хөрс-ургамлын судалгаа хийж бичиглэл үйлдэж дээж авах
4	Хөрсний элэгдэл эвдрэлийн судалгаа хийх, зэрэглэлийг тогтоох
5	Талбайн налуужилтыг тодорхойлох
6	Тариалан ба атаржсан газарт хөрсний зүсэлт хийх, дээж авах
7	Хөрсний холимог дээж болон химиин бохирдлын дээж авах
8	Хөрсний механик бүрэлдэхүүн, карбонат, чулуужилт, элсэн хуримтлал, ялзмагт давхаргын нимгэрэлтийг газар дээр нь тогтоох
9	Хог ургамал, хортон мэрэгчдийн тархалт, эзлэх хувийг тодорхойлох
10	Автогенийн нөлөөлөлд орсон газрын хил заагийг зурагт оруулах
5. Материал боловсруулалтын үе шат	
1	Хээрийн судалгааны үед авагдсан бүх төрлийн мэдээллийг байршлын координатаар нь зурагт оруулах
2	Хээрийн судалгааны үед суулгасан мониторингийн цэгийн хувийн хэргийг бүрдүүлэх
3	Хээрийн судалгааны үед тодорхойлогдсон хөрсний төрөл, янз дүрсүүдийг лабораторийн шинжилгээний дүнгээр бататган кодлож, нэгж талбарын сүлжээний зурагт эцэслэн оруулах
4	Тариалан ба атаршсан газрын төлөв байдал, чанарын үзүүлэлтүүдийг кодлон хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зурагт холбон атрибут мэдээллийг үүсгэх
5	Хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зургийн топологи алдааг засварлах
6	Төлөв байдал чанарын дэлгэрэнгүй болон товчоолсон хүснэгтийг боловсруулах
7	Тариалан болон атаршсан газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны судалгааны ажлын тайлан бичих
8	Атаршсан болон тариалангийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлт гаргах
6. Ажлыг хянуулах, хүлээлгэн өгөх	
1	Хянан баталгааны ажлыг захиалагч байгууллагад шалгуулах
2	Захиалагчаас өгсөн засварыг хийх
3	Захиалагч байгууллагын хурлаар хэлэлцүүлж дүгнэлт гаргуулах

## 1.БЭЛТГЭЛ АЖИЛ

### 1.1.Мэдээлэл цуглуулах

1. Төрөөс болон орон нутагт хэрэгжүүлж буй тариалангийн газрын талаарх бодлого чиглэл, цаашдын зорилтын талаар судалж тодруулна. Тухайн орон нутгийн газар ашиглалт, эзэмшилттэй холбоотой эрх зүйн акт, баримтын бүрдэлт, ашиглалт хамгаалалтын онцлогийг судлан тодорхойлно.
2. Сум орон нутгийн болон нэгж талбар доторхи хөрс, ургамлан нөмрөгийн бүрхэвч, түүний онцлогтой холбогдох судалгаа шинжилгээний материалтай танилцаж тэмдэглэл хөтөлнө.
3. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаатай холбогдол бүхий хууль тогтоомж, заавар, удирдамжийг судлах, урьд өмнө хийсэн судалгааны зураг, материалтай танилцсан, судалж дүн шинжилгээ хийсэн байна.
4. Тариалангийн газартай холбоотой статистик мэдээ (усан хангамж, жилийн дундаж ургац), газрын нэгдмэл сангийн тайлан, бусад шаардлагатай тоо баримтыг цуглуулна. Төмс, хүнсний ногооны газрууд, хүлэмж бүхий газруудын бүртгэл судалгааг хийж, байршлыг ажлын зурагт оруулна.
5. Сүүлийн 5-аас доошгүй жилийн байгаль, цаг уурын мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх бөгөөд уур амьсгалын зураглалыг ажлын зурагт оруулна.
6. Өмнө хийгдсэн тариалангийн газрын судалгаа, хянан баталгааны ажлын мэдээллүүдийг харьцуулан судалж, үнэлэлт дүгнэлт өгөх ба агаар, сансрын зургаас тодорхойлогдсон мэдээллийг харьцуулан өөрчлөлтийг тогтооно.
7. Тухайн нутаг дэвсгэрт гадаад, дотоодын эрдэм шинжилгээний байгууллага, орон нутагт хэрэгжсэн төслийн хүрээнд гүйцэтгэсэн тариалангийн газартай холбоотой судалгааны ажлын зураг, тайлангаас хянан баталгаа хийх үндсэн үзүүлэлтийг харьцуулан дүн шинжилгээ хийнэ.
8. Сансрын зураг, газар ашиглалт, хөрс, ургамлын зураглал, кадастрын зураг, байр зүйн зураг, газрын нэгдмэл сангийн тооллого, бүртгэл зэргийг үндэслэн, хянан баталгааны нэгж талбарын тоо, талбайн хэмжээ зэргийг тоймлон тодорхойлж, хээрийн ажлын нарийвчилсан төлөвлөгөө, урьдчилсан маршрутыг боловсруулна. Ингэнээр тухайн талбайд хянан баталгаа хийх ажлын хэмжээг тогтоож, гарах зардлыг нарийвчлан тооцох боломж бүрдэнэ.
9. Агаар, сансрын зургаас ургамал болон хөрсөн бүрхэвчийн төлөв байдал, элс хуримтлагдсан газар, усны элэгдэл эвдрэлтэй газар, авто зам, гадаргын механик өөрчлөлт, физик-геологийн үйл явц үзэгдлийн тархалт, гадаргын усны төлөв байдал зэрэг үзүүлэлтийг тодруулж, ажлын зурагт буулган харьцуулалт хийж дүгнэнэ.
10. Нэгж талбар дотор, гадны нөлөөгөөр үүсч бий болсон хөрсний элэгдэл, эвдрэл, зулгаралт, газрын гадаргуугийн өөрчлөлт, бохирдолт болон физик-геологийн үйл явц, үзэгдлийн байршлыг ажлын зурагт тэмдэглэсэн байна.

11. Бэлтгэл ажлын хүрээнд хөрс, ургамлын зураг, газар ашиглалтын төрөл, нягтаршлыг харгалzan бичиглэл, дээж авах цэг, мониторингийн (хяналтын) цэгийг урьдчилан төлөвлөх бөгөөд цэгийн байршил, солбицолыг ажлын зурагт оруулна.

- Бичиглэлийн цэг дээр зүйлийн бүрэлдэхүүн, ургамлын бүрхэц, ургац тодорхойлно.
- Дээж авах цэг дээр хөрсний малталт хийх, хөрсний дээж авна.
- Мониторингийн цэгт дээрх бүх ажилбар хийгдэнэ.

12. Хянан баталгаа хийх газрын байгалийн ба газар ашиглалтын онцлогийг харгалzan хээрийн ажил гүйцэтгэх багийг бурдүүлж, томилолт, унаа, зөвлөгөө, удирдамжаар хангах бөгөөд хээрийн судалгаа хийх маршрутыг ажлын зурагт оруулсан байна.

13. Хянан баталгааны ажилд аймгийн газрын асуудал эрхэлсэн байгууллагын мэргэжилтэн, сумын газрын даамлыг заавал оролцуулах тул гүйцэтгэгч хээрийн судалгаа эхлэхээс өмнө холбогдох газарт мэдэгдэж, оролцох мэргэжилтэн, албан тушаалтныг томилуулсан байна.

14. Хээрийн судалгаанд ашиглах ажлын зураг, 100x100 см-ийн тор, модон гадас, хүрз, өрөм, метр, шугам, жин, рулет, гадас, 20-30 м урттай цагаан утас, солбицлыг тодорхойлох GPS, бичиглэлийн маят, фото аппарат, цагаан самбар, цагаан самбарын арилдаг бал, дээжний уут, хаяг, балын харандаа болон бусад шаардагдах багаж хэрэгслийг бэлтгэнэ.



Зураг 1. Цагаан самбар ашиглах жишээ /зурагт цаад талбай харагдахаар байна/  
Самбарт дараах мэдээллийг дэс дараалуулж бичнэ.

1. Аймгийн нэр
  2. Сумын нэр
  3. Цэгийн төрөл /бичиглэлийн, мониторингийн, дээж авсан/
  4. Цэгийн дугаар
  5. Солбицол
  6. Он сар өдөр
15. Хээрийн ажлын удирдамж, төлөвлөгөө, бэлтгэл ажлын тайланг боловсруулж захиалагчид хүргүүлж, ажил шалгасан дүгнэлт гарсаны дараа хээрийн судалгааны ажлыг эхлүүлнэ.

## **1.2.Нэгж талбар**

Хянан баталгааны ажлыг хянан баталгааны нэгж талбарт тулгуурлаж гүйцэтгэх бөгөөд нэгж талбарыг дараах зарчмаар хуваана. Үүнд:

- Экологийн нэгж талбарт бүлэглэх (газрын гадарга, хөрс, ургамлан нөмрөг)
- Газар ашиглалт (үр тариа, төмс, хүнсний ногооны талбай, хүлэмжийн аж ахуй г.м.)

Экологийн нэгж талбар гэсэн ойлголтонд хөрсний тархалт, ургамлан нөмрөг, газрын гадарга буюу уул, хөндий, голын хөндий зэрэг газрын гадаргын хэлбэрийг харгалзана. Өөрөөр хэлбэл хөрсний хэв шинжээр тариалангийн хянан баталгааны нэгж талбарыг ангилна.

Тариалангийн болон атаршсан талбай бүрийг хянан баталгааны 1 нэгж талбар гэж үзнэ.

Тариалангийн тухай хуульд зааснаар атаршсан газар гэдэгт 3 жил тариалалт, уринш хийгээгүй тариалангийн газрыг хамааруулах бөгөөд эдгээрийг хянан баталгааны ажлын хүрээнд тодорхойлно.

Нэгж талбарын талбайн хэмжээнээс хамааруулан мониторингийн цэг, бичиглэлийн цэг, дээж авах цэгийг тогтооно.

Энэ норматив баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт, арга зүйн дагуу газрын төлөв байдал, чанарын үзүүлэлтийг тодорхойлно.

### **Нэгж талбарын дугаарыг мэдээллийн сан болон хүснэгтэд тэмдэглэх**

Мэдээллийн санд нэгж талбарыг дугаарлахдаа аймаг, сумын кодыг ашиглана.

Бэлчээрийг В үсгээр, тариаланг Т үсгээр, хот сууринг С үсгээр тус тус тэмдэглэх бол захиалгат хянан баталгааны нэгж талбарын дугаар газрын кадастрын нэгж талбарын дугаартай ижил байна. Эдгээр үсгүүдийг латинаар бичнэ.

Аймаг, сумын кодыг Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код, MNS5641-0-2006 2x, MNS5641-1-2006 6x, MNS5641-2-2006 34x, MNS5641-3-2006 47x стандартад заасны дагуу тэмдэглэнэ.

Нэгж талбарын дугаар өгөх: T650100001/120

Т-тариалангийн хянан баталгаа, 65-аймгийн код, 01-сумын код, 00001-нэгж талбарын дугаар, 120- талбайн хэмжээг га-аар илэрхийлнэ.

Нэгж талбар шинээр үүссэн бол өмнөх улсын хянан баталгааны дугаарыг үргэлжлүүлэн дугаарлана.

Нэгж талбар хуваагдсан тохиолдолд T220100001/60a, T220100001/60b гэж дугаарлана.

Хэрэв өмнөх хянан баталгааны нэгж талбарын дугаар өөр өгөгдсөн бол түүнийг хайж олох хүснэгтийг тайланд хавсралтаар оруулна. Жишээ нь:

№	Газрын нэр	Өмнөх нэгж талбарын дугаар	Одоо өгч байгаа нэгж талбарын дугаар
1	Нэмнэн	90300030	T2116000467/120

### Нэгж албарын дугаарыг зурагт тэмдэглэх

Хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зурагт нэгж талбарын дугаар, талбайн хэмжээг тэмдэглэнэ. 000001/120

**Мониторингийн цэг тэмдэглэх:** M1T650100001/120

Нэгж талбарын дугаарын өмнө латин үсэг, тоогоор тэмдэглэнэ. M1- мониторингийн цэгийн дугаар, Т-тариалангийн хянан баталгаа, 65-аймгийн код, 01-сумын код, 00001-нэгж талбарын дугаарыг илэрхийлнэ.

**Ургамлын бичиглэлийн цэг тэмдэглэх:** B1T650100001/120

Нэгж талбарын дугаарын өмнө латин үсэг, тоогоор тэмдэглэнэ. B1- бичиглэлийн цэгийн дугаар, Т-тариалангийн хянан баталгаа, 65-аймгийн код, 01-сумын код, 00001-нэгж талбарын дугаарыг илэрхийлнэ.

**Хөрсний дээж авсан цэг тэмдэглэх:** D1T650100001/120

Нэгж талбарын дугаарын өмнө латин үсэг, тоогоор тэмдэглэнэ. D1- хөрсний дээж авсан цэгийн дугаар, Т-тариалангийн хянан баталгаа, 65-аймгийн код, 01-сумын код, 00001-нэгж талбарын дугаарыг илэрхийлнэ.

### 1.3.Агаар, сансрын зураг ашиглах

Хянан баталгаа хийхийн өмнөх 4-5 жилийн (жил бүрийн 7-8 сард авсан, үүлгүй, 10 мийн нарийвчлалтай) агаар, сансрын зургийг боловсруулж, жил бүрийн ургамлын нормчилсон индекс (NDVI)-ийн зураглал хийнэ. Агаарын зураг, дрон (нисгэгчгүй нисэх төхөөрөмж)-оор авсан зураг ашигласан бол боловсруулалтыг зааврын дагуу хийсэн байна.

Жил бүрийн зургийг давхцуулан харьцуулж, дүгнэн тайланд дэлгэрэнгүй тайлбарлаж оруулна.

Дээрх боловсруулалт хийсэн зургаас хөрсний элэгдэл, эвдрэл, үер усны нөлөө, элсний нүүлт зэрэг нөлөөлөлд өртсөн газрын мэдээллийг тодорхойлж, ажлын зурагт тэмдэглэж, хээрийн судалгаагаар тодруулалт хийнэ.

Агаар, сансрын зураг авсан эх сурвалж, хэрэв боловсруулалт хийсэн бол ашигласан програм, зураг боловсруулалтын арга зүйн талаар бэлтгэл, эцсийн тайланд тодорхой, дэлгэрэнгүй тусгасан байна.

### 1.4.Ажлын зураг

Ажлын зураг нь хянан баталгааны ажлын суурь зураг болох төдийгүй тухайн ажил хийгдэж дуустал эх материал болж ашиглагдана.

Урьд өмнө хийгдсэн судалгааны материал, баримт бичиг, статистикийн тоо баримт, газрын нэгдмэл сангийн тооллого, газрын улсын бүртгэлийн мэдээлэл, өмнө хийгдсэн хянан баталгааны материал, өвөлжөө, хаваржааны байршлын зураг, 1:100000 масштабтай хөрс, ургамлын зураг, агаар, сансрын зураг, хянан баталгаа хийхээс өмнөх 4-5 жилийн ургамлын нормчилсон индекс (NDVI)-ийн зураг ашиглан, 1:100000 масштабтай байр зүйн зурагт тулгуурлан ажлын зураг бэлтгэнэ. Өөрөөр хэлбэл байгаль, цаг уур, хөрс, ургамал, газар ашиглалт, агаар сансрын зураг, өмнө хийгдсэн зурган болон тоон мэдээллийг ашиглан ажлын зураг бэлтгэнэ. Ажлын зурагт дараах тоон мэдээлэл суурь байдлаар ашиглагдах бол зарим мэдээллийг ажлын зурагт шинээр тэмдэглэнэ. Жишээ нь:

1. Хянан баталгаа хийгдэж байгаа аймаг, сумдын хилийн цэс, өмнө хийгдсэн хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зургийг тоон хэлбэрээр,
2. 1:100000 масштабын хөрс, ургамал, газрын нэгдмэл сангийн зургийг тоон хэлбэрээр,
3. 1:100000 масштабын байр зүйн тоон зургийг тоон хэлбэрээр газрын асуудэл эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын архиваас авч ашиглана.
4. Газрын кадастрын мэдээллийн сангийн зургийг тоон хэлбэрээр газрын асуудэл эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас авч ашиглана.
5. Өмнөх хянан баталгааны ажлаар тогтоосон бичиглэл хийсэн, дээж авсан цэгийг ажлын зурагт тэмдэглэнэ.
6. Шинээр байгуулах мониторингийн, бичиглэлийн, дээж авах цэгийн байршлыг ажлын зурагт тэмдэглэнэ.

## 1.5. Мониторингийн цэг

Газрын гадаргын төрх байдал, хөрсний хэв шинж, газар ашиглалтын байдалд дүгнэлт хийж, ажлын зураг дээр мониторингийн цэгийг урьдчилан тодорхойлж, хээрийн судалгаагаар тодруулалт хийнэ.

Тариалан /төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ, тэжээлийн ургамал г.м/, атаршсан талбай тус бүрт мониторингийн цэгийг тогтооно.

Мониторингийн цэгийг сонгоходоо дараах шалгуураар шалгасан байна. Үүнд:

1. Газрын гадарга
2. Хөрсний зонхилох хэв шинж
3. Экологийн хувьд ижил төстэй байх
4. Бусад талбайг төлөөлж чадахуйц
5. Ашиглалтын зориулалт
6. Усалгаатай, усалгаагүй
7. Нөлөөллийн үзүүлэлтээр

Мониторингийн цэгт дараах судалгааг хийнэ.

1. Хөрсний малталт хийх

2. Хөрсний бичиглэл хийх
3. Хөрсний механик бүрэлдэхүүн үзэх /хээрийн нөхцөлд
4. Ялзмагт үеийн зузаан тодорхойлох
5. Хөрсний дээж авах
6. Хог ургамлын бичиглэл хийх
7. Фото зураг авах

Мониторингийн цэг нь нэг биш нилээд хэд хэдэн талбайг төлөөлөх учир эдгээр талбайн 70-аас доошгүй хувь нь судалгаанд хамрагдсан байна. Судалгаанд хамрагдаж байгаа талбай бүрээс хөрсний дээж авч холин, шижилгээний дээжийг бүрдүүлэх ба энэ нь тухайн мониторингийн цэгийн дээж болно.

Фото зураг авахдаа ойр орших уулыг болон онцлох тэмдэг бүхий газрыг фон болгон, цагаан самбарт холбогдох мэдээллийг бичиж, фото зургийг авч, цэгийн байршлыг ажлын зурагт тэмдэглэнэ. Самбарт дараах зүйлийг тэмдэглэж, фото зургийг авна.

- Аймгийн нэр
- Сумын нэр
- Цэгийн төрөл /бичиглэлийн, мониторингийн, дээж авсан/
- Цэгийн дугаар
- Солбицол
- Он сар өдөр

Мониторингийн цэгийн дугаарыг энэ аргачилсан зааврын 1.2-т заасны дагуу дугаарлаж, цэг бүрт хувийн хэргийг бүрдүүлнэ. Үүнд:

1. Хувийн хэргийн нүүр хуудас “... аймгийн .... сумын тариалангийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны мониторингийн сүлжээний .... дугаартай цэгийн хувийн хэрэг, ... он” гэсэн гарчигтай байна.
2. Мониторингийн цэгийн газрын гадаргын болон байршлын ерөнхий мэдээлэл
3. Мониторингийн цэгийн хөрсний бичиглэл
4. Ургамлын бичиглэл
5. Мониторингийн цэгийн хянан баталгааны дүгнэлт буюу паспорт
6. Өмнө хийсэн хянан баталгааны үр дүнтэй харьцуулсан дүн шинжилгээ, дүгнэлт

#### **1.6.Бичиглэлийн цэг:**

Бичиглэлийг дараах 2 тохиолдолд хийх бөгөөд энэ зааврын 1.2-т заасны дагуу дугаарлана.

1. Мониторингийн цэг дээрх хөрс, ургамлын мэдээллийг баталгаажуулах зорилгоор

2. Маршрут судалгааны явцад зайлшгүй нэмэлт хэмжилт хийх шаардлагатай бол

## 1.6.Хөрсний хээрийн судалгаа

### 1.6.1.Хөрсний зүсэлт, малталт хийх

Тариалан, атаршсан газарт хөрсний хэв шинжээр бүтэн зүсэлт хийнэ. Харин малталтыг 0-60 см хүртэл гүнд хийж болох ба тухайн хөрсний үе давхрагаас хамаарна. Зүсэлт болон малталтын тэгш хана нь нарны эсрэг байх ба 5 см-ийн өнгө бүхий алсгалттай метр тавьж, хөрсний бичиглэл хийж, зүсэлтийн фото зургийг авна. Байгалийн байдлаараа нурсан гуу жалга ашиглан хөрсний зүсэлт малталт хийхгүй байхад анхаарна.

Тариалангийн талбайд хөрсний зүсэлт хийсэн бол хагалгааны үе давхарга болон түүний доод хэсгээс дээж авна.

Ойр орших уул болон онцлох тэмдэг бүхий газрыг фон болгон /эсвэл цагаан самбар ашиглах/ дээж авсан цэгийн фото зургийг авч, солбицолыг тодорхойлж, зүсэлтийг 3-1, малталтыг M-1 гэж дугаарлаж, байршлыг ажлын зурагт тэмдэглэнэ.

Хөрсний ялзмагт үеийн зузааныг тогтоох, элэгдэл, эвдрэлийн зэрэглэлт тогтоох, хог ургамлын тархалтыг тодорхойлох хэмжилтийг 3-5 давталттай хийнэ.

### 1.6.2.Хөрсний дээж авах

Хөрсний дээжийг энгийн ба холимог гэж ангила.

- Хөрсний зүсэлтийн үе давхрагаас нэг бүрчлэн энгийн дээж авна.
- Хөрсний ерөнхий шинж чанар, түүнд агуулагдах шим тэжээлийн бодисын дундаж хэмжээг тогтоох зорилгоор холимог дээж авна.

Хөрсний зүсэлтээс энгийн дээж, мониторингийн цэгт холимог дээж авна.

Холимог дээжийг зөвхөн хагалах үеийн хүрээнд, дээж авах цэг хоорондох зай тэнцүү байхаар тооцож, талбайг диагоналдан явж авна. Талбайн хэмжээнээс үл хамаарч, талбай тус бүрээс 7 цэгээс холимог дээж авна.

Холимог дээжийг бүрдүүлэхдээ бүх нэг дээж ижил хэмжээтэй байхад анхаарна. Бүх дээжийг авсаны дараа сайтар холиод, ойролцоогоор 50\*50 см орчим хэмжээтэй нимгэн мод, хатуу зузаан цаасан дээр жигд дэлгэж түүнээс түүвэрлэн авна. Хөрс чийг ихтэй тохиолдолд дээж наалдаж, холилдох нь мууг анхаарахын зэрэгцээ түүнийг сэврээх шаардлагатай. Ердийн нөхцөлд дээжийн жин 500 г байна.

Үр тарианы талбайгаас хөрсний үржил шимийг тодорхойлох зорилгоор хөрсний холимог дээжийг дараах давталтаар авна. Үүнд:

1. 200 га хүртэлх талбайгаас 1
2. 200-400 га бол 2
3. 400-аас дээш талбайд 3

Газар ашиглалтын зориулалтаас хамаарч хөрсний дээж авах гүн харилцан адилгүй байна.

- Үр тариа, тэжээлийн ургамал, атаршсан талбайн хөрсний 0-20 см гүнээс,
- Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалсан талбайн хөрсний 0-20 см, 20-40 см гүнээс хөрсний дээж авна.

Хөрсний дээж хаягтай байх бөгөөд дараах мэдээллийг балын харандаагаар бичиж, утнаас бэхэлнэ. Хөрсний хаягийг хөрсний дээж хийсэн уутанд хийж болохгүй.

- Дээжний дугаар .....
- Аймаг, сумын нэр.....
- Солбицол .....
- Хянан баталгааны нэгж талбарын дугаар .....
- Дээж авсан гүн, см .....
- Огноо .....
- Дээж авсан хүний нэр .....

Хөрсний дээжнүүдийг холилдуулахгүй байхад анхаарч тээвэрлэнэ.

### 1.7. Бэлтгэл ажлын тайлангийн агуулга

- **Нүүр хуудас** хүрээтэй байх ба дотор нүүр хуудсанд захидал болон ажилтнууд гарын үсэг зурж, тамга дарсан байна. (ЗАХИАЛАГЧИЙН НЭР /үсгийн хэмжээ 12, томоор/, АЖЛЫН НЭР /16, томоор/, ГҮЙЦЭТГЭГЧИЙН НЭР /14, томоор/, УЛААНБААТАР, ...ОН /12, томоор/)
- **Гарчиг** (Хуудасны дугаартай байх)
- **Ерөнхий мэдээлэл** (ажлын зорилго, зорилт, гэрээний дугаар, хугацаа, гүйцэтгэгчийн нэр, тусгай зөвшөөрлийн талаарх товч мэдээлэл, баримталсан эрх зүйн баримт бичгийн нэр /жагсаалт, баталсан эрх бүхий этгээдийн нэр/ /хуулийн заалтуудыг нэг бүрчлэн бичихгүй/, урьд нь тухайн хянан баталгааг гүйцэтгэсэн талаарх мэдээлэл, гүйцэтгэх ажлын хүрээнд хийхээр төлөвлөсөн ажлын жагсаалт, хугацаа, биелэлт, цуглуулсан материалын жагсаалт, дүн шинжилгээ хийсэн арга г.м)
- **Ажлын зураг боловсруулсан тухай** (агаар, сансрын зураг боловсруулалтын тухай буюу хиймэл дагуулын нэр, танилцуулга, авсан эх сурвалж, дугаар, нийт сцений /цуваа/ тоо, нарийвчлал, файлын хэмжээ, зураг ашиглан тодруулалт хийсэн болон NDVI зураглал хийсэн арга зүй, ажлын зураг боловсруулахад хэрэглэсэн зураг мэдээллийн жагсаалт, эх сурвалж, он, зөрүүтэй байдлыг зассан тухай тайлбар, үндэслэл, өмнөх хянан баталгааны зургийн тусгагт шилжүүлсэн эсэх, ажлын зургийн үндсэн тусгаг, боловсруулалт хийсэн програм, ажлын зурагт тэмдэглэсэн цэгийн төрөл, солбицолын жагсаалт, үндэслэл, эх сурвалж, он, хээрийн судалгааны маршрут, дроноор авсан зураг ашигласан бол зургийн талаарх мэдээлэлийг энэ бүлэгт бичнэ. Ажлын зурагт уур амьсгалын болон хянан баталгааны нэгж талбарын зураг, мониторинг, дээж авах, бичиглэл хийх цэгийн байршил, хөрсний зураг, зүсэлт хийх цэг, шинээр атар хагалсан газрууд зэргийг харуулсан байна)
- **Байгаль, нутаг дэвсгэрийн ерөнхий нөхцлийн мэдээлэл** (хянан баталгаа хийгдэж байгаа газрын газар зүйн байршил, газрын гадарга, цаг уур, хөрсөн бүрхэвч, ургамалжилтын мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийж,

тайлбарлан бичнэ. Мөн холбогдох зурган мэдээллийг /газрын гадаргын өндөржилтийн зураг, цаг уурын зураг, хөрс, ургамлын зураг/ оруулна. Сансрыйн зураг, газар ашиглалт, хөрс, ургамлын зураглал, кадастрын зураг, байр зүйн зураг, газрын нэгдмэл сангийн тооллого, бүртгэл, газар ашиглалтын статистик мэдээлэл, газрын нэгдмэл сангийн тайлан, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, тайлбарыг оруулна. Энэ бүлгийг эцсийн тайланда ашиглах тул сайтар бичихээс гадна эх сурвалж, оныг заавал өгүүлбэр бүрийн ард хаалтанд оруулах, ашигласан материалын жагсаалтад цагаан толгойн дарааллаар оруулсан байна.)

- **Хээрийн судалгааны ажлын төлөвлөгөө** /хээрийн судалгаа хийх ажлын төлөвлөгөө, оролцох хүмүүсийн нэр, гүйцэтгэх үүрэг, хугацаа зэргийг хүснэгтээр харуулна. Хээрийн судалгааны маршрут, км, урьдчилан тогтоосон дээж авах, бичиглэл, мониторингийн цэгийн тоо, байршил зэргийг зургаар харуулж, дэлгэрэнгүй тайлбарласан байна. Хээрийн судалгаанд ашиглах техник, багаж хэрэгслийн жагсаалт, лабораторын болон бусад чиглэлээр хамтран ажиллах гэрээний хуулбар, хамтрагч байгууллагын хийх ажлын жагсаалт, шинжилгээний арга, хугацаа, үнэ өртөг, магадлан итгэмжлэгдсэн эсэх, лабораторийн товч түүх г.м/
- **Ашигласан материалын жагсаалт:** Хууль, журам, зааврыг хамгийн эхэнд оруулах ба зохиогчийн болон байгууллагын бүтээлийг тус тусад нь цагаан толгойн үсгийн дарааллаар жагсаана. Жагсаахдаа зохиогчийн нэр, овгийн үсэг, зохиолын нэр, хэвлэсэн он, хэвлэсэн газар/баталсан байгууллагын нэр зэрэг дарааллаар бичнэ.
- **Хавсралт:** (орон нутгийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн албан бичиг, хамтран ажиллах гэрээний хуулбар г.м)
- **Баталгааны хуудас**

(Архивын шаардлага: Тайлан засваргүй гэж үзсэн бол нүүрэн талд 2 хуудас хүснэгт оруулж, тайлангийн хуудас бүрийг дугаарлаж, архивын (бор) хавтсаар хавтаслаж, үдсэн (цагаан утас) байна)

## 1.8. Бэлтгэл ажлын захиалагчийн хяналт

Бэлтгэл ажлын тайланг 2 хувь хэвлэж, захиалагчид албан бичгийн хамт ирүүлэх бөгөөд газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хариуцсан нэгжийн хөдөө аж ахуйн газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хариуцсан мэргэжилтэн ирүүлсэн тайланг дараах байдлаар шалгана. Үүнд:

1. Тайланг аргачилсан зааварт заасан агуулгаар бичигдсэн эсэх (дэд гарчиг бүрт заасан санааг оруулсан байдал)
2. Найруулгын болон үсгийн алдаа байгаа эсэх
3. Эх сурвалжийг дурьдсан эсэх (Эх сурвалж /ном, сэтгүүл, иш татсан материал/ ашигласан тохиолдолд нэр, хуудасны дугаар бичсэн байна.)
4. Зураг, хүснэгтийн нэр, масштаб, таних тэмдэг ашиглалт
5. Байгаль нутаг дэвсгэрийн ерөнхий мэдээлэл ойлгомжтой бичигдсэн байдал

Хэрэв тайлан энэ шаардлагыг хангаагүй бол ажил шалгасан акт гарахгүй байх болон хээрийн судалгаанд гарахгүй байх үндэслэл болно.

## ХОЁР.ХЭЭРИЙН СУДАЛГАА

Хээрийн судалгаа нь хянан баталгааны ажлын гол хэсэг бөгөөд үүнээс ажлын гол үр дүн хамаарна.

Хээрийн судалгаа нь ярилцлагын судалгаа, хөрсний судалгаа, цэг тогтоох, захиалагчийн хяналт гэсэн хэсгээс бүрдэнэ.

Хээрийн судалгааны ажилд орон нутгийн газрын асуудал эрхэлсэн төрийн захирагааны байгууллагын тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтэн, сумын газрын даамал заавал оролцоно. Энэ нь хээрийн судалгаанд орон нутгийн төлөөллийг оролцуулах, хээрийн судалгааг газар дээр нь хэрхэн хийж байгаатай танилцах, суралцах, захиалагчийн хяналтын үүргийг давхар гүйцэтгэх боломж бүрдэнэ.

Үр тариа, тэжээлийн ургамлын, төмс, хүнсний ногоо, таримал ургамал жимсгэний талбай болон атаршсан газрын хэмжээг кадастрын зурагтай тулгаж шинээр үүссэн талбайг тодруулалт хэмжилт хийж, зохих масштабын нарийвчлалтайгаар зурагт тусгана.

Гадаргын төлөв байдал, гадны хүчин зүйлийн үйлчлэлээр бий болсон хөрсний элэгдэл, эвдрэл, ургамлын тусгаг бүрхэц, гадаргын бохирдолт, ашиглалтын байдлыг судлан тодорхойлно.

Нэгж талбаруудын тоо, хил заагийг нарийвчлан тогтоож, хээрийн судалгааны дэлгэрэнгүй бичиглэл хөтлөн, нэгж талбар бүрт дугаар олгож, үнэлэлт дүгнэлт өгнө.

Үр тариа, тэжээлийн ургамлын талбай, төмс, хүнсний ногоо тариалсан талбай, таримал ургамал, жимс жимсгэний талбай, гадаргын ерөнхий тогтооцоос шалтгаалж элэгдэл, эвдрэлд орох, цөлжилт, элсний нүүлтэд өртөх, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлэх бодит нөхцөл байгаа эсэхийг тодруулна.

Хянан баталгааны нэгдсэн үзүүлэлтийн хүснэгт, цэгийн мэдээлэл, төрх байдал ба нөлөөллийн үзүүлэлтийг бүрэн гүйцэд бөглөнө.

### 2.1.Ярилцлагын судалгаа

- Хээрийн судалгааны ажлыг эхлэхийн өмнө орон нутгийн удирдлага, аймгийн байгаль орчин, хөдөө аж ахуйн болон газрын асуудал хариуцсан төрийн захирагааны байгууллагын удирдлага, мэргэжилтэн, сумын газрын даамал нарт гүйцэтгэгч хянан баталгааны ажлын зорилго, чиглэл, ач холбогдол, хээрийн судалгаа хийх газрууд, хийгдэх ажлыг дэлгэрэнгүй танилцуулна.
- Нөгөө талаар энэ уулзалтаар аймаг, орон нутгаас авч хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээ, тариалангийн газрын төлөв байдлыг тандах, хөрсний үржил шим, түүний өөрчлөлтийн талаар санал солилцох, сүүлийн жилүүдэд элэгдэж эвдэрсэн, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан газрыг тодорхойлох, элсний нүүлт, хөрсний үржил шимиийн ерөнхий байдлыг судлах, элэгдэж эвдэрч байгаа газрын байршлыг тогтоох, орон нутгийн хүмүүс,

тариаланчдаас санал асуулга авах, атаршиж хаягдсан газрыг нэг бүрчлэн тогтоох, шинээр хагалсан газрыг тогтоох, тариалангийн талбайн ашиглалтын талаар судалгаа, мэдээллийг цуглуулж, мэдээллийг ажлын зурагт тэмдэглэнэ. Мөн шалтгаан нөхцөл, үр дүн, гарсан зардлын талаар нарийвчлан тэмдэглэж, тайланд тусгана.

3. Бэлтгэл үе шатанд тогтоосон хээрийн судалгааны маршрутыг хэлэлцэж, орон нутгийнханы саналыг харгалзан судалгаа хийх нэмэлт газруудыг тодорхойлж, ажлын зурагт тэмдэглэж, судалгааны маршрутыг тодотгоно.
4. Орон нутгийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын архивт болон сумын газрын даамалд байгаа тариалангийн газрын төлөв байдал, чанарын улсын болон захиалгат хянан баталгаатай холбоотой акт, баримт бичгийн бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалт, ашиглалтын талаар дүгнэлт хийж, хээрийн ажлын тайланд тусгасан байна.

Ярилцлагын арга нь сумын удирдлага, тариаланчдын орлцоог хангах, хээрийн судалгааны маршрутыг тодотгох, шаардлагатай газруудын мэдээлийг нарийвчлах, хээрийн ажлын маршрут, хугацааг хэмнэх зэрэг олон давуу талтай тул зайлшгүй хийх шаардлагатай.

## 2.2. Хянан баталгааны үзүүлэлтийг тодорхойлох

Тариалан, атаршсан газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны үзүүлэлт

Хүснэгт 3

№	Үндсэн үзүүлэлт	Дэд үзүүлэлт	Тодорхойлох арга
1	Хөрсний үржил шимт үе давхаргын зузаан	-	Зүсэлт, малталт хийж см-ээр хэмжинэ.
2	Хөрсний ялзмагийн агууламж	-	Тюриngийн арга
3	Хөрсний орчин (PH)	-	Хээрийн нөхцөлд эсвэл лабораторит
4	Нитрит азот	-	
5	Хөдөлгөөнт фосфор	-	Мачигиний арга
6	Хөдөлгөөнт кали	-	Мачигиний арга
7	Шингээх багтаамж	-	
8	Гадаргын төрх байдал	Хөрсний элэгдэл, эвдрэл	Агаар, сансрын зургаас
		Хөрсний бохирдолт	Хээрийн судалгаа болон лабораторид бордоо, гербицид, пестицидийн үлдэгдэлийг тодорхойлох
		Үндэслэг ишээр ба үндэсний хэсгээр үрждэг хог ургамлын тархалт	Нүдэн баримжааны арга буюу А.И.Мальцевийн аргаар
		Хөрсний хоёрдогч давсжилт, намагжилт	Хээрийн болон лабораторын аргаар

Атаршсан талбайд эдгээрээс гадна дараах нэмэлт үзүүлэлтийг тодорхойлно.

Хүснэгт 4

№	Үндсэн үзүүлэлт	Дэд үзүүлэлт	Тодорхойлох арга
1	Ургамлын формациын өөрчлөлт	<ul style="list-style-type: none"><li>Шарилжны үе</li><li>Хиаг, алаг өвсний үе</li><li>Үетэн, буурцагтны үе</li></ul>	100 м2 талбайд ургамлын бичиглэл хийх аргаар

Хянан баталгааны үзүүлэлтийг тодорхойлоходоо дараах зүйлийг анхаарах шаардлагатай. Үүнд:

- Хэмжилтийн үзүүлэлтууд жигд бус, хэмжилт хийх цэгийн сонголттой холбоотой ялгаа гарсан тохиолдолд давталтын тоон дундажийг бүрэн тодорхойлох хэмжээнд нэмэгдүүлнэ.
- Газар ашиглалтын зориулалтаас үл хамаарч хянан баталгааны нэг төрлийн ажиглалт хэмжилт, задлан шинжилгээнд хэрэглэх арга нэг стандартынх байна.
- Хэмжилт, задлан шинжилгээний нэг давталтын үзүүлэлт бусад давталтынхаас эргэлзээ төрүүлэхүйц зөрүүтэй гарах тохиолдол байдаг. Ийм нөхцөлд тухайн давталтын тоон үзүүлэлтийг арифметикийн дундажид оруулна.
- Б.А.Доспеховын сурх бичигт арифметик дундажийн эргэлзээтэй үзүүлэлтийг гишүүнээр авах, эсэх тухай шалгуурыг ашиглан, таамаглалыг шалгана. Өөрөөр хэлбэл ажиглалт, задлан шинжилгээний аливаа үзүүлэлтийг шинжээчийн санаагаар дүгнэлтээс хасах эсвэл эргэлзээтэй байснаар санал нийлэхгүй бусадтай адилтган үзэж болохгүй.

## 2.2.1. ТАРИАЛАНГИЙН ТАЛБАЙН СУДАЛГАА

### 1. ХӨРСНИЙ ҮРЖИЛ ШИМТ ҮЕ ДАВХАРГЫН ЗУЗААН

Хөрсний үржил шимиийн үндсэн үзүүлэлтийн нэг бол ялзмаг агуулж байгаа хөрсний давхарга юм.

“Байгаль дээр нийцээрээ байгаа хөрсөнд 1см ялзмагт давхарга бий болоход 100-аас илүү жил шаардагдана” гэж үздэг. Үүнээс үзэхэд хөрсний ялзмагт давхаргын зузаан бий болох нь маш удаан, харин устаж үгүй болох нь маш түргэн юм.

Хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, дунд зэргийн зузаан давхаргатай хүрэн хөрсний ялзмагт давхаргын зузаан, ялзмагийн агууламжийг Д.Аваадорж, Ш.Пүрэвсүрэн нар судалж, ялзмагт (A) давхаргын зузаан  $21.7 \pm 0.32$  см, ялзмагийн агууламж  $2.31 \pm 0.08\%$ , харин шилжилтийн (AB) давхаргын зузаан  $13.4 \pm 0.58$  см, ялзмагийн агууламж  $1.92 \pm 0.08\%$  орчим байна гэж тогтоосон байна.

**Тодорхойлох арга:** Хөрсний зүсэлт, малтарт хийж, ялзмагт үеийн зузааныг тодорхойлох бөгөөд хөрсний бичиглэлийн маягтанд тэмдэглэнэ. Үүний тулд газрыг багажаар ухаж /хүрз, өрөм г.м/ ил гарсан ханы дагуу см-ийн хуваарьтай метр, шугам ашиглаж, зузааныг хэмжиж тодорхойлно. Зүсэлт, малтартын хананы нүүрэн тал нарны эсрэг байхаар тооцож зүсэлт, малтартыг хийх ба фото зургийг авч тайланд оруулна.

Хөрсний ялзмагт үе давхрагын зузааныг тодорхойлохдоо хөрсний А ба АВ үе давхарга буюу ялзмагт үе давхрагын зузаан 0-20 см бол нимгэн, 20-40 см бол дунд зэргийн зузаан, 40 см-ээс дээш бол зузаан гэж ангилдаг.

Ялзмагт үеэс дараагийн үед шилжих шилжилт ямар хэлбэрээр (тод ба тод бус) байгааг хөрсний бичиглэлд онцлон тэмдэглэнэ.

Ялзмагт үеийн зузааныг талбайн янз бүрийн хэсэгт буюу хэд хэдэн давталттай хийж, дундаж үзүүлэлтийг гаргана. Давталт хэдий чинээ олон байх тутам төдий чинээ сайн. Давталтын 60-аас доошгүй хувийг заавал малталаар хийх ба бусдыг ялангуяа үзүүлэлт өөр хоорондоо жишиж болохуйц ойролцоо байвал хөрсний өрмөөр хэмжиж болно.

Тухайн суманд голлон тархсан хөрсний хэв шинжийг сонгон, тариалангийн болон атар хөрсний ялзмагт үеийн зузааныг харьцуулна.

Ялзмагт үеийн зузааны өөрчлөлт хөрсний элэгдэл эвдрэлийн нэг үндсэн үзүүлэлт болно гэдгийг давхар бодолцож, бодитой тодорхойлоход анхаарах хэрэгтэй.

**Анхаарах асуудал:** Хэмжилтийг хийхдээ эргүүлж хагалсан хэсэгт, үе давхарга холилдсон эсэхийг сайтар анхаарах хэрэгтэй. Ялзмагт үеийн зузааныг тодорхойлоход гадаргын дээр, дор өөрөөр хэлбэл хагалгааны шан, хувил, мөн хөрсийг гүн хагалсаны дараа ялангуяа булдаагуй байхад хөрс хөвсийж эзэлхүүн томтой байдгийг анхаарах шаардлагатай. Иймд хөрсний гадаргаас хэмжилт хийхдээ хөрсний суултыг 20 хувиар тооцож хэмжилт хийнэ.

## 2.ХӨРСНИЙ ЯЛЗМАГИЙН АГУУЛАМЖ

Ялзмаг нь хөрсний үржил шимийг тодорхойлох үндсэн үзүүлэлт болдог. Хөрсөнд хэдий чинээ их ялзмаг агуулагдана, төдий чинээ ус, агаар, дулааны болон физик-механикийн шинж чанар сайн байна гэж үздэг. Монгол орны хөрс ерөнхийдөө ялзмаг багатай. Хөрсний ялзмагийн хэмжээ, хөрсний хэв шинж, дэд хэв шинж, төрөл, зүйл, дүрс зэргээс хамааран харилцан адилгүй.

Ялзмаг агуулалтын хэмжээ хөрсний хэв шинж, дэд хэв шинж тэдгээрийн дотор механик бүрэлдэхүүнээс хамаарч нэлээд хэлбэлзэлтэй. Хүнд механик бүрэлдэхүүнтэй хар хүрэн хөрсний ялзмаг агуулалт 3-4 хувь байхад хөнгөн механик бүрэлдэхүүнтэй цайвар хүрэн хөрснийх 2.0-оос бага хувьтай юм. Олон жилийн судалгааны дунджаар манай орны хар шороон хөрс 5-10%, хар хүрэн хөрс 3-5 %, хүрэн хөрс 2-3 %, цайвар хүрэн хөрс 1,5-2 %-ийн ялзмаг агуулдаг.

**Тодорхойлох арга:** Хөрснөөс дээж авч, лабораторын нөхцөлд Тюриngийн аргаар ялзмагийг тодорхойлно.

“Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд -MNS3298-1991” стандартын дагуу хөрсний дээж авна.

## 3.ХӨРСНИЙ УРВАЛЫН ОРЧИН

Хөрсний уусмал дахь устэрөгчийн ионы хэмжээг аравтын урвуу логарифмаар илэрхийлсэнийг хөрсний хүчиллэг буюу pH гэнэ.

Устөрөгчийн ионы хөрсөн дэх байрлалаас хамаарч хүчиллэгийг идэвхитэй ба нөөц гэж ангилдаг. Нөөц хүчиллэгийг солилцох ба гидролит (усан) гэж бас ялгана.

**Тодорхойлох арга:** Хөрсний PH хээрийн нөхцөлд эсвэл лабораторит тодорхойлно.

Хөрсний pH-ийг тодорхойлоходо түүнийг усаар ба давсны уусмалаар зайлж хольцыг бэлтгэнэ. Усаар зайлсан уусмалыг идэвхитэй хүчиллэг, харин давсаар зайлсан уусмалыг солилцох хүчиллэг гэнэ. Солилцох хүчиллэг нь идэвхитэй хүчиллэгээс ямагт бага байна. Солилцох хүчиллэг нь хөрсийг шохойжуулах шаардлагыг тогтооход чухал ач холбогдолтой. Хөрсийг бордоход солилцох хүчиллэгийг заавал тооцоолох шаардлагатай. Хөрсний орчинг дараах байдлаар ангилна. Үүнд:

Саармаг үед	PH =7
Хүчиллэг үед	PH <7
Шүлтлэг үед	PH >7

#### 4.НИТРИТ АЗОТ

**Тодорхойлох арга:** Лабораторын нөхцөлд тодорхойлно.

#### 5.ХӨДӨЛГӨӨНТ ФОСФОР

**Тодорхойлох арга:** Мачигиний аргаар тодорхойлно.

#### 6. ХӨДӨЛГӨӨНТ КАЛИ

**Тодорхойлох арга:** Мачигиний аргаар тодорхойлно.

#### 7.ГАДАРГЫН ТӨРХ БАЙДАЛ

Тариалангийн талбайн гадаргын төрх байдлын өөрчлөлтөд юуны өмнө суваг шуудуу, далан, барилга байгууламж багтана.

Газрын гадаргууд гарсан механик зулгаралт, нүх, овоолсон шороо, элсжилт, уруйн үерийн ул мөр, хог хаягдал, техногений бохирдол зэргийг бичиглэлд бичиж, хил зааг, талбайн хэмжээг ажлын зурагт тэмдэглэнэ. Мөн талбайг тэгшилсэн дэнжилж тавцан гаргаж зассан зэрэг үйл ажиллагааг бичиглэлд тодорхой тусгана.

Эдгээр өөрчлөлтийг үйлдвэрлэлийн зорилгоор хийж үр ашгаа өгөхийн зэрэгцээ хүрээлэн буй орчиндоо сөрөг нөлөөлөхгүй тохиолдолд үнэлэлт дүгнэлтийг зэрэг талаас өгч болно.

Гадаргын төрх байдлын өөрчлөлтөд орсон талбайн хэмжээ нийт талбайн 10 хувь болон түүнээс дээш хэмжээтэй бол талбайгаар, үүнээс бага бол цэгээр зурагт тэмдэглэнэ.

Тариалангийн хувьд гадаргын төрх байдлын нэг гол үзүүлэлт нь чулуужилт юм. Манай орны ихэнхи тариалангийн талбайд ажиглагддаг хайрга болон жижиг үйрмэг чулуу агротехнологид нөлөөлдөггүй.

Хэрэв чулууны хэмжээ 3 см диаметртэй буюу түүнээс том хэмжээний чулуутай бол чулуужилтийн зэрэглэлийг тогтооно. Үүнд:

1. 5-15% бага
2. 16-30% дунд
3. 31%-аас дээш бол их

Чулуужилтын зэрэглэлийг тариалан болон атаршсан талбайд адил тодорхойлно.

### 8.1. Хөрсний элэгдэл эвдрэл

Тариалангийн талбайд газрын чанарыг муутгадаг үзэгдэл бол хөрсний элэгдэл, эвдрэл юм. Иймээс газрын төлөв байдал, чанарын хянан баталгаанд ялангуяа тариалангийн газарт хөрсний элэгдэл эвдрэлийг судлах, түүний зэрэглэлийг тогтоох шаардлагатай.

Хөрсний элэгдэл, эвдрэлийг судлахад хээрийн ба лабораторийн аргыг өргөн хэрэглэх ба энд зөвхөн хээрийн судалгаанд гүйцэтгэх ажиглалт хэмжилтийн аргын тухай авч үзнэ.

Монгол орны нөхцөлд тариалангийн газрын хөрс салхиар хийсэх нь их бөгөөд усаар угаагдах үзэгдэл харьцангуй бага тул хөрс салхиар хийсэх элэгдэлийг илүү авч үзэх шаардлагатай.

Хөрсний элэгдэл, эвдрэлийн төлөв байдал, зэрэглэлийг тогтоохдоо генетик-морфологийн болон газар зүйн байрлалаараа адил, унаган төрхөөрөө байгаа хөрстэй харьцуулалт хийнэ.

Тариалангийн талбай нэг доор бөөн бие дэрлэн орших нөхцөлд жишиг болох хөрсийг зөв сонгох хэрэгтэй.

Ялангуяа анхны хянан баталгаа хийх хугацаанд ялзмагт үеийн угуул зузааныг зөв тогтоох чухал юм. Талбайн зах буюу атарт ялзмагт үеийн жишиг зузааныг 4-өөс дээш давталтын дунджаар тодорхойлох бол талбай дотор ялзмагт үеийн угуул зузааныг олон дахин давтан үзэх шаардлагатай.

Хөрсний гадаргын төрх байдал, хөдөлгөөн, тэнд хурсан элс шорооны хэлбэр ба зузаан, мөн түүнчлэн тарималын өсөлт хөгжилтийн байдалд ажиглалт хэмжилт хийнэ.

Тариалангийн талбай ба түүний захад хурсан элс шорооны зузааныг мөн түүнчлэн үрэлгээний мөрний дарагдалт зэргийг хэмжиж, элс шорооны хуралтын хэлбэрийг тэмдэглэнэ. Энэ ажиглалт, хэмжилтийг талбайн салхины дээр ба доор мөн төв хэсэгт 5-аас доошгүй давталттай тодорхойлно.

Мөн үр тарианы ургамал соёололтынхoo шатанд шороон шуурганаас шалтгаалж цөөрсөн тоог тогтоох боломжтой бөгөөд шаардлагатай тохиолдолд уртааш метр замд 8-аас доошгүй давталттай тодорхойлно.

Тариалангийн талбай налуу газар буюу уулын ам хөндий зэрэгт байрласан тохиолдолд усны шугаман болон нэлэнхүй угаагдал хөрсөнд илэрнэ.

Нэлэнхүй элэгдэл, эвдрэл хөрсний үе давхаргийн нимгэрлээр илрэх ба хажуу шугаман элэгдэл, эвдрэл нь гуу жалга хэлбэрээр илэрнэ. Иймээс тариалангийн талбайд үүссэн гуу жалга, судгийн урт өргөн, гүнийг хэмжиж, зурагт тэмдэглэж, үйлдвэрлэлд нөлөөлөх талаар үнэлэлт, дүгнэлт өгнө.

Талбайн захаар автомашины замын эмх цэгц алдагдсанаас замаар ус гүйх улмаар шалбааг тогтох хөрс усаар угаагдах, намагжих явдал байдгийг бодож үзэх хэрэгтэй.

Хөрс боловсруулалтын үйл ажиллагаагаар тэгшрээд байхаар ховил, шан зэргийг хөрсний элэгдэл, эвдрэлд тооцох хэрэггүй.

Ялангуяа усалгаатай төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний талбайд, хөрс давсжих мөн намагших үзэгдэл илэрч магадгүй. Энэ тухай ажиглалт хийж ялангуяа хөрсний гадарга өнгөртсөн тохиолдолд химиин задлан шинжилгээнд зориулж дээж авна. Талбайн хөрс нийтдээ бус алаглаж давсжих тохиолдол цөөнгүй. Ийм нөхцөлд давсжсан хилийг зурагт нарийн тусгана.

Хүнсний ногоо, жимс жимсгэний жижиг, тухайлбал 1 га хүртэл талбайд тариалангийн талбайд гүйцэтгэх ёстай бүхий л ажиглалт хэмжилтийг нэг бүрчлэн хийх шаардлага тодорхой нөхцөлд гарахгүй байж болно. Тухайлбал айл өрхийн эзэмшилд байгаа хүнсний ногооны жижиг талбайг тэр бүр дээж авах, олон давталттай хэмжилт хийх шаардлагагүй.

Тариалангийн талбайн хөрсний доройтолын зэргийг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тогтоож болно.

#### Хүснэгт 4

Зэрэглэл	Ялзмаг агууламжийн өөрчлөлт, %	Ялзмагт үе давхрагын нимгэрэлт, %	Физик шаврын алдагдал, %	Элсэн хуримтлалын зузаан, см
Сул	5-15	5-25	2-4	5-10
Дунд зэрэг	15-40	25-50	7-12	10-25
Хүчтэй	40 бага	50 бага	12 бага	25 бага

### 8.2.Хөрсний бохирдол

Тариалангийн хөрсний бохирдолтод юуны түрүүнд гербицидийн үлдэгдэл ялангуяа хүнсний ногооны талбайд нитратийн хэт хуримтлал, мөн неоматод зэрэг багтана.

Манай орны тариаланд янз бүрийн хор хэрэглэж байгаа бөгөөд тухайлбал атразин, битоксибациллии, гранозан, метафос, хлорофос, зенкор, цинеб зэрэг хор хэрэглэдэг. Эдгээр нь хөрсөнд үлдэх магадлал багатай бөгөөд харин бүтээгдэхүүнээр хорны сөрөг үйлчлэлийг дамжиж болно гэж үздэг.

2006 онд батлагдсан Химиин хорт болон аюултай бодисын тухай хуульд “Пестицид” гэж мал, амьтан, ургамлыг аливаа өвчинөөс сэргийлэх, хөнөөлт шавьж,

мэрэгч, хогийн ургамлаас хамгаалах зориулалттай химиин бодис, тэдгээрийн нэгдлийг хэлнэ гэж тодорхойлсон.

Эрдэмтэдийн үзэж байгаагаар пестицидийг хэзээ, хэн, ямар нөхцөлд яаж хэрэглэх талаарх заавар, журмыг сайтар мөрдөж ажилласан тохиолдолд хэрэглэгчдэд очих хүнсэнд агуулагдах үлдэгдэл пестицидийн хэмжээ үлэмж бага байдаг. Харин уг химиин бодисуудыг зөв хэрэглэх талаар зохих заавар, журмыг мөрдөж ажиллаагүй тохиолдолд хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй юм.

Пестицидийг химиин бүтцээр нь хлор арганик, фосфор органик, мөнгөн ус органик, циант нэгдлүүд, зэс хүхрийн бэлдмэл, органик метал агуулсан нэгдэл хэмээн ангилдаг. Тэдгээрийг хэрэглээний зориулалтаар нь инсекцид, фунгицид, гербицид гэж ангилдаг.

2000 оноос хойш жил бүр Байгаль орчин, Хүнс хөдөө аж ахуйн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар “Ургамал хамгаалалтын зориулалтаар ашиглаж болох пестицидийн жагсаалт, хэрэглэх хэмжээ”, “Мал эмнэлгийн ариутгал, халдвартгүйтгэлийн зориулалтаар ашиглаж болох пестицидийн жагсаалт, хэрэглэх хэмжээ”, “Газар тариалангийн зориулалтаар ашиглаж болох химиин бордооны жагсаалт, хэмжээ”, “Ахуйн хортон шавьж, мэрэгч устгалын болон ариутгал, халдвартгүйтгэлийн зориулалтаар ашиглаж болох бодисын жагсаалт, хэрэглэх хэмжээ”- г тус тус баталсан.

Тариалалт, хадгалалтын явцад жимс, ногоо, үр тариаг шавж, ургамлын өвчнөөс сэргийлэх, чанарыг нь алдагдуулахгүй байх зорилгоор пестицид, гербицид, фунгицид г.м. бодисыг хэрэглэдэг. Энэ нь хурдан үйлчилдэг, хямд сайн талтай ч тариалалтын явцад хэрэглэсэн эдгээр бодис хураалтын дараа бүтээгдэхүүндээ тодорхой хэмжээгээр үлддэг. Үүнтэй холбоотойгоор сүүлийн үед жимс, хүнсний ногоон дахь пестицидийн үлдэгдэл, тэдгээрийн хүний эрүүл мэндэд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлж байгаа эсэх асуудал хэрэглэгчдийн анхаарлыг татах болсон.

Монгол улс ургамал хамгаалал, газар тариаланд химиин арга хэрэглээд нэгэн жарны нүүр үзэж байгаа ч эдгээр бодисын хэрэглээн дээр хяналт тавих, хөдөө аж ахуйн зөв дадал, тандалтын тогтолцоо, цаашилбал пестицидийн зөв менежментийг одоо хүртэл бүрдүүлж чадаагүй байна.

Пестицидийн бодисыг импортоор орж ирэх явцад хяналт тавьдаг ч тариалан эрхлэх явцад хяналт тавьдаггүй, иргэд бодистой харьцах үедээ хөдөмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, хэрэглэх зааврыг мөрдөн ажилладаггүй, сургалтанд бүрэн хамрагдаж чаддаггүй, өөрөөр хэлбэл хөдөө аж ахуйн зөв дадал одоо хүртэл нэвтрээгүй байна. Түүнчлэн пестицидийн мэдээллийн нэгдсэн сан байхгүй, төмс, хүнсний ногоон дахь пестицидийн үлдэгдэл хэмжээг зөв тодорхойлон үнэлгээ, дүгнэлт өгч чадахгүй байгаа дутагдал одоо ч байсаар байна

2011 оноос хойш Монгол улсын газар тариалангийн салбарт хэрэглэж буй бодисын дийлэнх нь гилофосат (раундап, торнадо нэрээр) бөгөөд энэ нь хүний эрүүл мэндэд хоруу чанар харьцангуй багатай, дэлхийд хамгийн өргөн хэрэглэдэг гербицид юм. Түүнчилэн паракуат, тебуkenазол (булат, скарлет, бункер), лямбдацигалотрин (каратэ), фенизан (дикамбын хүчил+хлорсульфуроны хүчил), феноксапроп-П-этил (пумасупер, ластик, овсюген нэрээр), метсульфурон метил (алмазис, магнум, зингер) г.м. пестицидуудийг хэрэглэж байна.

Айл өрхийн эзэмшилд байгаа хүнсний ногооны жижиг талбайг тэр бүр дээж авах олон давталттай хэмжилт хийх шаардлагагүй байж болно.

Хэрвээ гербицид үзэх шаардлага гарвал хагалгааны гүнээс холимог дээж авах ба 8-аас доошгүй цэгээс авч холино. Дээж авах цэгүүдийг талбайд жигд байрлуулах, тэмдэглэх, мөн холилтын үед технологийн алдаа гаргахгүй байхад анхаарна. Дээжний жин ойролцоогоор 1 кг орчим байна.

Хөрсөнд гербицид, пестицид, химиин бодисын үлдэгдлийг “Хөрсний чанар. Органик хлорт пестицид ба полихлорт бифенилийн агууламжийг электрон баригч детектор бүхий хийн хроматографиар тодорхойлох MNS ISO 10382-2012” стандартад заасны дагуу тодорхойлно.

Шинжилгээний үр дүнг “Байгаль орчны бохирдол, бохирдлын хяналт ба хамгаалалт - Агаар, хөрсөн дэх пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6147:2010” стандарттай харьцуулна.

Тариалангийн ялангуяа усалгаатай төмс, хүнсний ногооны талбайд нематодын тархалттай холбогдсон ажиглалт хэмжилт хийх шаардлага гарч болзошгүй.

Төмсний цайвар шаргал нематод, өмнөтийн урын нематод хөрс бохирдуулах магадлалтай тул тэдгээрийг Монгол улсад хориотой объектын жагсаалтад оруулж, гадаадаас таримал ургамалтай хамт манай нутагт нэвтрүүлэхийг хориглосон байдаг.

Манай орны байгаль цаг уурын нөхцөлд нематод үржин олшрох бололцоо бага байдаг. Хур бороо элбэгтэй дулаан үед хааяа ишний болон урын нематод төмс хүнсний зарим ногоонд үржиж хөнөөл учруулах нь тохиолдоно. Мөн энэ нөхцөлд цаг уурын тааламжтай нөхцөл бүрдсэн үед ишний нематод үржиж болох юм. Үүний үрээр хөрс нематодын халдвартай болж улмаар таримлын ургац, чанарыг бууруулах аюултай.

Хөрсөнд нематодыг тодорхойлоходо талбайд хөрсний холимог дээжийг ердийн аргаар авч, түүнийг шигшүүрээр шигшиж, нематодын урыг ялгана. Хөрсний холимог дээжийг шигшиж, нарийн хэсгийг усанд хийхэд цистүүд хөвнө. Дээрх аргаар ялгаж авсан цистүүдийг тоолж, хөрсний нэгж эзэлхүүнд ногдох нематодын тоог тогтооно.

### 8.3. Хог ургамлын тархалт

Тариалангийн талбайн ашиглалт, үйлдвэрлэлийн зардал хэмжээ, чанарт хог ургамал, түүний дотор үндэслэг ишээр ба үндэсний хэсгээр үрждэг хог ургамал нэн хортой.

Үндэслэг ишээр ба үндэсний хэсгээр үрждэг хог ургамал талбайн захаар хэсэг хэсгээр толборч тархдаг. Гэхдээ талбайд хог ургамлын тархалт жигд бус учраас нийтийг төлөөлөх цэгийг сонгох асуудал хүндрэлтэй бөгөөд эцсийн үр дүнд хүчтэй нөлөөлнө.

Нийт талбайд хог ургамлын эзлэх хувиар үнэлэх нь заримдаа хялбар бөгөөд илүү үнэмшилтэй болдог. Хог ургамлын бүрхэцийг нүдэн баримжаагаар үнэлэх нь бүтээмж сайтай, цаг хугацаа, хүч хөдөлмөр, зардал харьцангуй бага шаарддаг. Иймд хог ургамлын тархацыг А.И.Мальцевийн аргыг өргөн ашигладаг.

Үнэлгээ

Балл	Хог ургамлын тархалт	Үнэлгээ
1	Тариалангийн талбайд хог ургамлын ганц нэгээрээ харагдаж байвал	Сул
2	Хог ургамал хэд хэдээрээ тааралдаж байвч тарималдаа далдлагдаж байвал	Дунд
3	Хог ургамалд элбэг тохиолдож байвч таримал нь давамгайлж байвал	Хүчтэй
4	Хог ургамал нь тарималаа давамгайлж байвал	Их хүчтэй

#### 4.Хөрсний 2 догч давсжилт, намагжилт

Хөрсний хоёрдогч давсжилт, намагжилт усалгааны нормыг хэтрүүлснээс үүсэх бөгөөд илрэх хэлбэр нь талбайгаар цайрч харагдана. Хөрсний давсжилт үүсэх гол нөхцөл нь тухайн услалтын системийг дренажийн сүлжээгүй барьснаар ихэвчлэн шалтгаалдаг.

Ялангуяа усалгаатай төмс хүнсний ногоо жимс жимсгэний талбайд, хөрс давсжих мөн намагших үзэгдэл илэрч магадгүй. Хөрсний гадарга өнгөртсөн тохиолдолд химиийн задлан шинжилгээнд зориулж хөрсний дээж авна.

Талбайн хөрс нийтдээ бус, алаглаж давсжих тохиолдол цөөнгүй. Ийм нөхцөлд давсжсан газрын хил, заагийг талбайн хэмжээнээс хамааруулан цэг болон талбайгаар зурагт тэмдэглэнэ.

#### 2.2.2.АТАРШСАН ТАЛБАЙН СУДАЛГАА

Атаршсан талбайд дээр дурьдсан үзүүлэлтүүдийг тодорхойлох ба зарим үзүүлэлтийг тодорхойлох шаардлагагүй.

Атаршсан талбайд юуны өмнө эргэлтээс хасагдсан шалтгааныг судлахаас эхлэхийн зэрэгцээ хөрсний үржил шим, ургамлан нөмрөгийг сэргээх талаар авсан арга хэмжээ, үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгнө. Ялангуяа хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын формацийн өөрчлөлтөд онцгой анхаарах хэрэгтэй.

Атаршсан газрын хөрсний элэгдэл эвдрэлийг дээр дурьдсан аргаар тодорхойлох боловч боловсруулалт хийгдээгүй хөрс нь сууж дагтаршсан, тарималгүй, ихэвчлэн нүцгэн гэдгийг онцгой анхаарна. Ер нь хөрс элэгдэж эвдэрсэн шалтгаанаар л эргэлтээс хасагдаж, атаршиж байгаа гэдгийг санах нь зүйтэй. Хөрсний элэгдэл эвдрэлийн төлөв байдал, зэрэглэлийг тогтоо давталтын тоо тариалангийнхаас харьцангуй цөөн байж болно.

Харин ургамлын формацийн өөрчлөлтөөр талбайн нөхөн сэргэлтийн түвшин, цаашид хөрөнгө хүч зарцуулах эсэх асуудлыг шийдэх юм.

Ургамлын формациын өөрчлөлтийг  $100\text{m}^2$  талбайд тодорхойлох бөгөөд 3 давталттай үзнэ.

Шарилж, лууль, нэг наст, хиаг, алаг өвснүүд, бэлчээрийн үетэн, буурцагт ургамлуудын арви, бүрхэц, зүйлийн бүрэлдэхүүнийг гарган, хичнээн хувийг эзэлж байгааг тодорхойлж, атаршнаас хойш аль формацид байгааг тогтооно. Үүнд:

1. Шарилжны формаци
2. Хиаг/Алаг өвсний формаци
3. Үетэн буурцагтаны формаци

Энэ судалгаанд үндэслэн ургамлан нөмрөгийн ба хөрсний тогтвортойлтын зэрэглэлийг тогтооно.

Атаршсан газрын хянан баталгааны үндсэн зорилт бол атаршуулж хаяад зөвхөн зуны улиралд шарилжинд бариулаад байхгүйгээр, богино хугацаанд талбайд үетэн ба алаг өвс ургуулах таатай нөхцлийг бүрдүүлж чадаж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөхөд оршино.

### 2.2.3. ТӨМС ХҮНСНИЙ НОГООНЫ ТАЛБАЙН СУДАЛГАА

Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний талбайд хянан баталгаа хийх ажил нь бусад талбайнаас эрс ялгаатай. Учир нь газар ашиглалтын эрчимжилтийн түвшингээрээ эрс ялгаатай бөгөөд газартай хөрөнгө оруулж элдэншүүлэлт сайн хийж, бордоо усалгаа хийдэг онцлогтой.

Хүнсний ногоо, жимс жимсгэний бүр жижиг, тухайлбал 1 га хүртэл талбайд тариалангийн талбайд гүйцэтгэх ёстай бүхий л ажиглалт хэмжилтийг нэг бүрчлэн хийх, дээж авах олон давталттай хэмжилт хийх шаардлагагүй байж болно.

Ногооны газрын талбайн хэмжээ олон жижиг хэсэгт хуваагдах бөгөөд давсжилт, намагжилт, хог ургамлын судалгаанд илүү анхаарах хэрэгтэй.

Олон жижиг талбайг хөрсний хэв шинж, газрын төрх байдлаар бүлэглэж, дээж авах, бичиглэл хийх цэгийг зөв сонгох замаар хянан баталгааг үр дүнтэй хийхэд анхаарна.

Ялангуяа усалгаатай төмс, хүнсний ногооны талбайд нематодын тархалттай холбогдсон ажиглалт, хэмжилт хийх шаардлага гарч болзошгүй.

### 2.3. Хээрийн ажлын тайлангийн агуулга

- **Нүүр хуудас** хүрээтэй байх ба дотор нүүр хуудсанд захидал болон ажилтнууд гарын үсэг зурж, тамга дарсан байна. (ЗАХИАЛАГЧИЙН НЭР /үсгийн хэмжээ 12, томоор/, АЖЛЫН НЭР /16, томоор/, ГҮЙЦЭТГЭГЧИЙН НЭР /14, томоор/, УЛААНБААТАР, ...ОН /12, томоор/)
- Гарчиг (хуудасны дугаартай байх)
- **Ерөнхий мэдээлэл** /хээрийн ажлын зорилго, зорилт, гэрээний дугаар, гэрээний хугацаа, мөрдсөн заавар, аргачлал /хуулийн заалтууд бичихгүй/, хээрийн ажил гүйцэтгэсэн аймаг, сумын нэр, хугацаа, багийн бүрэлдэхүүн, ажлын хэсгийн оролцоо, орон нутгийн оролцсон байдал/
- Уулзалт ярилцлага хийсэн тэмдэглэлийн хураангуй
- Хөрсний судалгаа, дээж авсан арга зүй, байршлын зураг

- Хээрийн судалгааны ажлын төлөвлөгөө /хүснэгт/, түүний гүйцэтгэлийн хувь, гүйцэтгэсэн хүмүүсийн нэр, ажил үргийн хуваарь, хугацаа, тэдгээрийн зөрүүтэй байдал
- Хээрийн судалгааны маршрут, гүйцэтгэлийн тайлбар /төлөвлөсөн маршрутаад өөрчлөлт орсон тухай бичих/
- Хээрийн ажилд ашигласан техник, багаж хэрэгсэл, ашигласан материалын жагсаалт
- Ажлын зургийн хуулбар /сум тус бүрээр А3 хэмжээтэй/, тайлбар, хээрийн нөхцөлд тодотгосон байдал /анх бэлтгэсэн зураг хээрийн судалгаагаар хэрхэн тодруулалт орсон тухай бичих/
- Мониторингийн болон хөрсний дээж авсан, ургамлын бичиглэлийн цэгүүдийн дугаар, тодорхойлолт, солбицолын жагсаалт, фото зураг, цэгүүдийн товч тодорхойлолт.
- Хээрийн ажил гүйцэтгэхэд тулгарсан бэрхшээл, түүнийг шийдвэрлэсэн байдал
- Хавсралт (аймаг, сум бүрээр хээрийн ажил гүйцэтгэсэн тухай тодорхойлолт, албан бичгийн хуулбар)
- Баталгааны хуудас

#### **2.4.Хээрийн ажлын захиалагчийн хяналт**

Гүйцэтгэгч хээрийн ажлыг эхлэх, дуусгахдаа 7-оос доошгүй хоногийн өмнө захиалагчид мэдэгдэж, хээрийн ажлын тайланг ирүүлнэ.

Энэ нь хээрийн ажлын захиалагчийн хяналт хийх бэлтгэл ажлыг хангах, хээрийн ажлыг шалгах удирдамж боловсруулах, хүний нөөц, техникийн бэлэн байдлыг хангах зорилготой.

Захиалагчийн хяналт дараах байдлаар хийгдэнэ.

1. Аймгийн засаг даргын захирамжаар аймгийн газрын асуудал эрхэлсэн төрийн захирагааны байгууллагын мэргэжилтэн, Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн, Сумын Засаг дарга, Газрын даамал, сумын мал үржлийн тасгийн дарга, мэргэжилтэн, сумын байгаль хамгаалагч гэсэн бүрэлдэхүүнтэй байгуулж, удирдамжийг батална. (Ажлын хэсэг гүйцэтгэгчийг хээрийн судалгаа хийх явцад хамтран явж хяналт хийж болно.)
2. Ажлын хэсэг хээрийн ажлыг газар дээр нь шалгаж, захиалагчийн хяналтын тайлан, дүгнэлтийг газрын асуудал эрхэлсэн төрийн захирагааны байгууллагад ирүүлнэ. Тайланд ажлын хэсгийн бүрэлдэхүүн баталсан тушаал, удирдамжийн хуулбар, дутуу, зөрүүтэй хийгдсэн ажлын жагсаалт, нэмж хийх ажлын жагсаалт, сумын эрх бүхийн албан тушаалтуудын оролцсон байдал зэргийг тусгасан байна.

Ажлын хэсгийн тайлан, дүгнэлт, мэргэжлийн хэлтсийн ажил шалгасан дүгнэлтийг үндэслэж хээрийн ажлын тайланг архивт хүлээн авна.

Мөн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас ажлын хэсэг байгуулж, удирдамжийн дагуу хээрийн ажлын гүйцэтгэлийг газар дээр нь түүвэрчлэн шалгана.

## ГУРАВ. МАТЕРИАЛ БОЛОВСРУУЛАЛТЫН АЖИЛ

Материал боловсруулалтын ажлын хүрээнд бэлтгэл болон хээрийн судалгааны явцад бүрдүүлсэн мэдээллийг нэгтгэх, боловсруулалт хийх, дүн шинжилгээ хийх, зураглах ажил хийгдэнэ.

Тайлан боловсруулах ажил нь лабораторын шинжилгээний дүгнэлтийг тайлбарлах, үндсэн мэдээллийг боловсруулах, дүгнэлт паспорт бичих, хавсралт хүснэгтийг боловсруулах, шаардлага бичих гэсэн хэсгээс бүрдэнэ

### 3.1.Үндсэн үзүүлэлт

Дараах үзүүлэлтүүдийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлох бөгөөд Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуульд заасны дагуу итгэмжлэл авсан лабораторит хийлгэнэ. Үүнд:

Лабораторын шинжилгээний үзүүлэлтүүд

Хүснэгт 6

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тодорхойлох арга
1	Ялзмаг	Хувь	Тюрины арга
2	Нитрит азот	мг/кг шороонд	1.0 н КСЕ-ийн хандмалын арга
3	Хөдөлгөөнт фосфор	мг/кг шороонд	Мачигиний арга
4	Хөдөлгөөнт кали	мг/кг шороонд	Дөлт фото метр
6	pH	Коэф	Потенциометр
7	Давсжилт	Хувь	Кондуктометр
8	Механик бүрэлдэхүүн	Хувь	Качинскийн арга

Давсжилтын шинж тэмдэг илэрсэн хөрсөнд давсжилтын шинжилгээг хийнэ.

Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуульд заасны дагуу хөрсний сорьц шинжилгээний чиглэлээр итгэмжлэл авсан лаборатори хийж гүйцэтгэнэ. Шинжилгээний дүнг лабораторын тамга, тэмдгээр баталгаажуулан, эх хувиар эцсийн тайланд хавсаргана.

### 3.2.Нөлөөллийн үзүүлэлт

Нөлөөллийн үзүүлэлтэд дараах үзүүлэлтүүд орно. Үүнд:

1. Талбайн налуу: тоогоор тэмдэглэх 1<sup>0</sup>
2. Чулуужилтын зэрэг: кодоор тэмдэглэх (маш бага, бага, дунд, их, маш их)
3. Хөрсний элэгдэл эвдрэл: кодоор тэмдэглэх (эвдрэлгүй, сул, дунд, хүчтэй)

4. Хөрсний шугаман эвдрэл: кодоор тэмдэглэх (эвдрэлгүй, сул, дунд, хүчтэй)
5. Хог ургамлын тархалт: кодоор тэмдэглэх (сул, дунд, хүчтэй, маш хүчтэй)
6. Хортон шавьж, мэрэгчдийн тархалт: хувиар
7. Зам, шугам сүлжээ байгаа эсэх: сонголтоор (тийм, үгүй)

Атаршсан талбайн хувьд дээрх үзүүлэлт дээр нэмж доорх үзүүлэлтийг авч үзнэ.

1. Ургамлын формацийн өөрчлөлт
  - Шарилжны үе
  - Хиаг, алаг өвсний үе
  - Үетэн, буурцагтны үе

Тариалан ба атаршсан газарт нөлөөлж байгаа үзүүлэлтийг дараах байдлаар тодорхойлно.

Нөлөөллийн үзүүлэлтийг тодорхойлох аргачлал

Хүснэгт 7

№	Нөлөөллийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Тодорхойлох арга	Зурагт тэмдэглэх хэлбэр
1	Талбайн налуу	град	Газрын гадаргын өндөржилтийн зургаас буюу Arc Gis программаар тодорхойлно.	Өндөржилтийн зургаар
2	Чулуужилтын зэрэг	%	Шигшүүрээр	Талбайгаар
3	Хөрсний элэгдэл эвдрэл	урт, өргөн	Агаар, сансрын зураг ашиглан тодорхойлж, хээрийн судалгаагаар тодруулна.	Талбайгаар
4	Хөрсний шугман эвдрэл	Урт, өргөн	Агаар, сансрын зураг ашиглан тодорхойлж, хээрийн судалгаагаар тодруулна.	Талбайгаар
5	Хог ургамлын тархалт	ш/м <sup>2</sup>	Мальцаын арга	Талбайгаар
6	Хортон шавьж, мэрэгчдийн тархалт	га	Нүдэн баримжааны арга	Талбайгаар
7	Зам, шугам сүлжээ байгаа эсэх	га	Зам, шугам сүлжээний байршлыг сансрын зургаас зураглаж тодорхойлно.	Шулуунаар
8	Шарилжны үе	Га	10*10 м <sup>2</sup> талбайд бичиглэл хийх	Талбайгаар
9	Хиаг, алаг өвсний үе	Га	10*10 м <sup>2</sup> талбайд бичиглэл хийх	Талбайгаар
10	Үетэн, буурцагтны үе	Га	10*10 м <sup>2</sup> талбайд бичиглэл хийх	Талбайгаар

### 3.3. Хянан баталгааны ажлын үндсэн мэдээллийг боловсруулах

Үндсэн мэдээллийг хүснэгт хэлбэрээр боловсруулах ба хүснэгт тус бүрийг өмнө хийсэн хянан баталгааны ажлын үр дүнтэй харьцуулан тайлбарлаж тайландаа оруулна. Хүснэгт болон тайланг заавал Arial фонд бичсэн байна.

Үндсэн мэдээлэлд дараах мэдээллийн орно. Үүнд:

1. Тариалангийн газрын төлөв байдал, чанарын дэлгэрэнгүй үзүүлэлт
2. Атаршсан талбайн төлөв байдал, чанарын дэлгэрэнгүй үзүүлэлт

3. Нөлөөллийн үзүүлэлт
  4. Тариалангийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлт
  5. Атаршсан газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлт
  6. Мониторингийн цэгийн хувийн хэрэг

Дэлгэрэнгүй үзүүлэлтийн хүснэгт нийт 24 үзүүлэлтээс бүрдэнэ.

1. Газрын нэр: .....
  2. Өмнөх нэгж талбарын дугаар:.....
  3. Одоогийн нэгж талбарын дугаар: T220100001/120
  4. Талбайн хэмжээ, га: 120
  5. Мониторингийн цэгийн дугаар: M1T220100001/120
  6. Мониторингийн цэгийн солбицол: X - 50° 18' 18.150"  
Y- 106° 29' 20.840"
  7. Өндөржилт, м:
  8. Дээж авсан цэгийн дугаар: D1T220100001/120
  9. Солбицол: .....
  10. Өндөржилт, м:
  11. Кадастрын нэгж талбарын дугаар:
  12. Эзэмшлийн хэлбэр: ЗДТГ, өмчлөл, эзэмшил
  13. Атар хагалсан он: 1968
  14. Талбай ашиглалт, сэлгээ: ур тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал, жимс- жимсгэнэ, уриншилсан, өнжөөсөн
  15. Хөрсний код: 31 оронтой
  16. Хөрсний нэр: уулын хүрэн хөрс
  17. Хөрсний механик бүрэлдэхүүн: элсэнцэр
  18. Ялзмаг агууламж: 3.2
  19. Ялзмагт үеийн зузаан, см: 25
  20. РН: .....
  21. Нитрат азот:.....
  22. Хөдөлгөөнт фосфор:.....
  23. Хөдөлгөөнт кали:.....
  24. Давсжилт:.....

..... аймгийн (аймгийн код) ..... сум (сумын код)-ын тариалангийн  
газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны үндсэн үзүүлэлт

### Хүснэгт 8

№	Газрын нэр	Үндсэн үзүүлэлт																								
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25
	Өмнөх нэгж талбарын дугаар																									
	Одоогийн нэгж талбарын дугаар																									
	Талбайн хэмжээ, га																									
	Мониторингийн цэгийн дугаар																									
	Солбицол																									
	Өндөржилт, м																									
	Дээж авсан цэгийн дугаар																									
	Солбилцол																									
	Өндөржилт, м																									
	Кадастрын нэгж талбарын дугаар																									
	Эзэмшилийн хэлбэр																									
	Атар хагалсан он																									
	Талбай ашиглалт, сэлгээ																									
	Хөрсний код																									
	Хөрсний нэр																									
	Механик бүрэлдэхүүн, %																									
	Ялзмагын агууламж, %																									
	Ялзмагт үеийн зузаан, см																									
	РН																									
	Нитрат азот, %																									
	Хөдөлгөөнт фосфор, мг/100г																									
	Хөдөлгөөнт кали, мг/100г																									
	Давсжилт, %																									

Тайлбар: Хөрсний код өгөх зааварчилгааг хавсралт 2-оос үзнэ үү.

### Нөлөөллийн үзүүлэлт

### Хүснэгт 9

№	Нэгж талбарын налуу, град	Талбайн чулуужилтийн зэрэглэл, %	Хөрсний элэгдэл эвдрэл, салхиар	Хөрсний шугаман тархалт, %	Хог ургамлын тархалт, %	Хортон шавьж, мэрэгчдийн тархалт, ш/м <sup>2</sup>	Зам, шугам сүлжээ дайрсан эсэх
1	2	3	4	5	6	7	8

Нэлөөллийн зэрэглэл ба код

Хүснэгт 10

Эвдрэлийн зэрэглэл	Хөрсний элэгдэл, эвдрэл, салхи	Шугаман элэгдэл, эвдрэл	Чулуужилтийн зэрэглэл	Хог ургамлын тархалтын зэрэглэл	Зам шугам сүлжээ байгаа эсэх
Эвдрэлгүй	1	1	Маш бага	1	Сул
Сул	2	2	Бага	2	Дунд
Дунд зэрэг	3	3	Их	3	Хүчтэй
Хүчтэй	4	4	Дунд	4	Их хүчтэй
		Маш их	5		

..... аймгийн (аймгийн код) ..... сум (сумын код)-ын атаршсан газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны үндсэн үзүүлэлт

ХҮСНЭГТ 11

## Атаршсан талбайн нөлөөллийн үзүүлэлт

### Хүснэгт 12

№	Нэгж талбарын дугаар	Төрх байдал ба нөлөөллийн үзүүлэлт				Ургамлын формацийн өөрчилэлт			
		Талбайн напуу, град	Чулуужилтийн зэрэглэл, %	Хөрсний элэгдэл эвдрэл	Хог ургамлын тархалт, %	Хортон шавьж, тархалт, ш/м <sup>2</sup>	Зам, шугам сүлжээ байгаа эсэх	Шарилжны үе	Хиаг, алаг өвсний үе

### Нөлөөллийн зэрэглэл ба код

### Хүснэгт 13

Эвдэрэлийн зэрэглэл	Хөрсний элэгдэл, салхи	Шугаман элэгдэл, эвдрэл	Чулуужилтийн зэрэглэл	Хог ургамлын тархалтын зэрэглэл	Зам шугам сүлжээ байгаа эсэх	Шарилжны үе	Хиагны үе	Үетэн буурцагтын үе
Эвдэрэлгүй	1	1	Маш бага	1	Сул	1	Тийм	10-15
Сул	2	2	Бага	2	Дунд	2	Үгүй	25-30
Дунд зэрэг	3	3	Их	3	Хүчтэй	3		15-20
Хүчтэй	4	4	Дунд	4	Их хүчтэй	4		
		Маш их	5					

Нөлөөллийн үзүүлэлтийн товчоо (хянан баталгааны акт бичихэд ашиглана.)

### Хүснэгт 14

Төрх байдал нөлөөллийн үзүүлэлтүүд	Нөлөөлөлд орсон Нэгж талбарын дугаар	Талбай, га
Талбайн напуу		
Чулуужилтийн зэрэг		
Хөрсний элэгдэл эвдрэл		
Хөрсний элэгдэл эвдрэл		
Хог ургамлын тархалт		
Хортон шавьж, мэрэгчдийн тархалт		
Зам, шугам сүлжээ байгаа эсэх		
Шарилжны үе		
Хиаг, алаг өвсний үе		
Үетэн, буурцагтын үе		
Нийт дун		

### **3.4.Өмнө хийсэн хянан баталгааны үр дүнтэй харьцуулах**

Өмнө хийсэн хянан баталгааны үр дүнтэй харьцуулж, өөрчлөлтийг тогтоох нь хянан баталгааны акт бичих гол эх сурвалж нь болно. Харьцуулалтыг дараах хүснэгтээр сум бүрээр хийнэ.

Харьцуулалт

Хүснэгт 15

№	Харьцуулах үзүүлэлт	2013 он	2018 он	Тайлбар
1	Нэгж талбарын тоо			
2	Нийт мониторингийн цэгийн тоо			
3	Тариалангийн талбай, га			
4	Тариалангийн талбай дээрх мониторингийн цэгийн тоо			
5	Атаршсан талбай, га			
6	Атаршсан талбай дээрх мониторингийн цэгийн тоо			
7	Төмс, хүнсний ногооны талбай, га			
8	Төмс, хүнсний ногооны талбай дээрх мониторингийн цэгийн тоо			

Харин тухай мониторингийн цэгийн хувьд хавсралт 6, 7-д заасан хүснэгтээр харьцуулалт хийж, тайлбарыг тайландаа дэлгэрэнгүй тусгана.

### **3.5.Мониторингийн цэгийн хувийн хэрэг бүрдүүлэх:**

Хувийн хэргийг хавсралт 5-д заасны дагуу бүрдүүлж, тайландаа хавсаргана.

### **3.6.Хянан баталгааны дүгнэлт бичих:**

Хянан баталгааны дүгнэлтийг 3 хэлбэрээр бичнэ. Үүнд:

- Газрын гадарга, хөрсний хэв шинж ижил газар байрлаж байгаа талбайг нэгтгэн нэг дүгнэлт
- 1 эзэмшигчтэй, харьцангуй том талбайтай бол талбай бүрээр дүгнэлт
- Мониторингийн цэг байрлаж байгаа болон холимог дээж авсан талбай бүрээр дүгнэлт

Атаршсан талбайн хувьд дээрхийн адил дүгнэлт бичигдэнэ.

Төмс, хүнсний ногооны талбайн хувьд таримлын төрөл, хөрсний төрөл, хөрс боловсруулалт, химийн бодисын хэрэглээнээс хамааруулан дээрх зарчмын дагуу бичигдэнэ.

Хянан баталгааны дүгнэлтэд хэмжилт, задлан шинжилгээний дундаж тоон утга ба түүний үнэлэлт дүгнэлт заавал бичигдэнэ.

### **3.7.Хянан баталгааны акт бичих**

Хянан баталгааны акт нь Газрын тухай хуулийн 50, 51-р заалтыг хэрэгжүүлэх, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх, газар зохион байгуулалтын арга хэмжээг тогтоож үүрэгжүүлэхэд чиглэнэ.

Хянан баталгааны актыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын ХАА газрын хянан баталгааны асуудал хариуцсан мэргэжилтэн сум бүрээр болон аймгийн хэмжээгээр гаргана.

Хээрийн ажиглалт хэмжилт, лабораторийн задлан шинжилгээний дүнг үндэслэн актыг гаргах бөгөөд дараах загварын дагуу гаргана.

... аймгийн ... сумын бэлчээрийн хянан баталгааны акт

Хүснэгт 16

Газрын нэр, нэгж талбар	Цаашид тариалангийн/ атаршсан талбайн ашиглалтад тавигдах шаардлага	талбай, га

Актыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга буюу хянан баталгааны улсын өрөнхий шинжээч баталгаажуулан, тухайн орон нутгийн захиргаа болон ХАА-н асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад албан ёсоор хүргүүлнэ.

Ялангуяа төлөв байдлын ба чанарын өөрчлөлт гарсан тохиолдолд ихээхэн анхаарал тавих хэрэгтэй. Өөрчлөлтийн үндэслэл ба зэрэглэл, шалтгаан, түүнд нөлөөлсөн хүчин зүйл, зерэг ба сөрөг талыг тодорхой баримт үндэстэй актад тусгана.

Мөн хээрийн ба материал боловсруулалтын хугацаанд ажиглагдаж байсан буюу тэмдэглэгдсэн хэдийгээр дүгнэлт гаргах үндэслэл болохооргүй ч гэсэн дараагийн хянан баталгааны ажилд мөн цаашдын газар ашиглалт, хамгаалалтанд анхаарах газрын төлөв байдал, чанарын онцлогийг тусгасан байна.

Акт хэдий чинээ дэлгэрэнгүй олон талаас нь авч үзсэн байх тутам төдий чинээ сайтар үндэслэлтэй болно. Хянан баталгааны дүгнэлтэд хавсаргах зураг ба шаардлагын бүрдэлтээр тухайн хянан баталгааны ажлын чанар тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл хянан баталгааны дүгнэлт, зураг, акт нь хянан баталгааны нэгдсэн тодорхойлолт болно.

### **3.8. Нэгж талбарын сүлжээний зураг боловсруулах**

Хянан баталгааны нэгж талбарын сүлжээний тоон зураг боловсруулах ажил дараах хэсэгтэй байна. Мэдээлэл оруулахдаа заавал Arial фонт ашиглана.

1. Зураглах
2. Хүснэгтэн мэдээллийг оруулах
3. Зургийн эх бэлтгэх, хэвлэх

### **3.8.1.Зураглах**

1. Хянан баталгааны нэгж талбарын сүлжээний тоон зургийг Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан WGS-84 солбицол, UTM тусгагт зураглана.
2. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас аймаг, сумын хилийг тоон хэлбэрээр авч ашиглах бөгөөд сумын төвийн тэг гортигийг тухайн сумын захиргаанд баримталж байгаа хилээр зураглана.
3. Цэг, шулуун, талбай хэлбэрээр зураглах ба эдгээр нь орон зайн мэдээллийн сангийн шаардлагыг хангасан хүснэгтэн мэдээллийн болон таних тэмдгийн загвартай байна.
4. Хянан баталгааны өгөгдлийн сангийн загварыг үндэсний орон зайн мэдээллийн санд нийцүүлэн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.
5. Тоон зургийн топологийн алдааг засварласан байна.

### **3.8.2.Хүснэгтэн мэдээлэл оруулах**

Хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зургийн давхарга бүр хүснэгтэн мэдээлэлтэй байх бөгөөд бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны өгөгдлийн сангийн загварын дагуу оруулна. Хүснэгтэд мэдээллийг заавал Arial фондоор бичнэ.

1. Тариалангийн талбай */үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал, жимс- жимсгэнэ, уриншилсан, өнжөөсөн тус бүрээр ялган зураглана/*
2. Атаршсан талбай
3. Мониторингийн цэг
4. Дээж авсан цэг
5. Бичиглэлийн цэг

Гүйцэтгэгч хянан баталгааны орон зайн мэдээллийг үндэсний орон зайн мэдээллийн санд оруулах бөгөөд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын орон зайн мэдээлэлийн асуудал хариуцсан нэгжээр дүгнэлт гаргуулж, эцсийн тайлангийн ард хавсаргана.

### **3.8.3.Зургийн эх бэлтгэх**

Хил залгаа аймаг, сумдын нэгж талбарын сүлжээний зургийн хил зааг уялдаж байгаа /тохирч байгаа/ эсэхийг захиалагч буюу орон зайн мэдээлэл, технологийн болон мэргэжлийн хэлтэс хамтран шалгаж дүгнэлт гаргана.

Зургийн эх бэлтгэхдээ заавал текст, тоог Arial фондоор, тохирох үсгийн хэмжээгээр бичнэ. Жишээ нь,

- зургийн нэр 14 (үсгийн хэмжээ)
- булангийн хүснэгт 10-аас доош (үсгийн хэмжээ)
- зургийн тайлбар 12-оор (үсгийн хэмжээ)
- таних тэмдэг, нэгж талбарын дугаар, мониторингийн цэгийн дугаар тохирох үсгийн хэмжээгээр бичнэ.

Зургийн үндсэн өнгийг талбайн ашиглалтаас хамааран өөр өөр байна.

Зургийн нэрийг өгөхдөө Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код, MNS5641-0-2006 2x, MNS5641-1-2006 6x, MNS5641-2-2006 34x, MNS5641-3-2006 47x стандартыг ашиглан аймаг, сумын кодыг бичнэ. Жишээ нь: *Архангай аймгийн (аймгийн код) Ихтамир сум (сумын код)-ын тариалан, атаршсан газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зураг*

Зургийн суурь таних тэмдгийг хийхдээ Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан стандартыг мөрдөнө.

- “Байр зүйн болон дэвсгэр зургийн загвар сан, таних тэмдэг. Масштаб: 1:500, 1:1000, 1:2000, 1:5000. MNS 6702:2017”,
- “Байр зүйн зургийн загвар сан, таних тэмдэг. Масштаб: 1:25000, 1:50000, 1:100000. MNS 6703:2017”

### ЗУРАГТ НЭГЖ ТАЛБАРЫН ДУГААР БИЧИХ

Зурагт нэгж талбарын дугаарыг 00001/120 гэж бичнэ. Нэгж талбарын дугаар, талбайн хэмжээг харуулсан байна.

Анхны хянан баталгааны нэгж талбарын дугаар өөрчлөгдөхгүй байна.

Харин шинэ нэгж талбарыг хамгийн сүүлийн нэгж талбарын дугаарлалтаас эхлэн дугаарлана.

Хэрэв нэгж талбар хуваагдсан бол a, b гэж ялгах нэмэлт дугаар өгнө. Өөрөөр хэлбэл 00001a/60, 00001b/60 гэж дугаарлана.

Хэрэв өмнөх хянан баталгааны нэгж талбарын дугаар өөр хэлбэрээр өгөгдсөн бол түүнийг олох хүснэгтийг тайланд тусгана. Жишээ нь:

Хүснэгт 17

№	Газрын нэр	Өмнөх нэгж талбарын дугаар	Одоо өгч байгаа нэгж талбарын дугаар
1	Нэмнэн	00001/120	00001a/60, 00001b/60

### ЗУРАГТ ХҮРЭЭ ОРУУЛАХ

Нэгж талбарын сүлжээний зурагт газар зүйн солбицолын тор хийх бөгөөд зураас нь харагдахгүй байна.

### ЗУРАГТ ХҮСНЭГТ ОРУУЛАХ

Хянан баталгааны зурагт мониторингийн, бичиглэл хийсэн, дээж авсан цэгийн мэдээллийг дараах хүснэгтээр оруулна.

Цэгийн мэдээлэл

